



ХОТ СУУРИН ГАЗРЫН АГААРЫН БОХИРДЛЫН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Судалгааны ажлын тайлан

Улаанбаатар хот

2014 он

Судалгааны багийн ахлагчид:

Очирын Чимэдсүрэн (ЭМШУИС-ийн НЭМС)

Кирк Смит (Бэркэлэй дэх Калифорнийн Их сургууль)

Судалгааны багийн гишүүд:

Л.Дрю Хил (Берkeley дэх Калифорнийн Их сургууль)

Балжиннямын Пүрэвдорж (ЭМШУИС-ийн НЭМС)

Дамдинсүрэнгийн Юмчиндорж (ШУТИС-ийн ЭХИС)

Одсүрэнгийн Мөнхтуул (ЭМШУИС-ийн НЭМС)

Руфус Эдвардс (Ирвин дэх Калифорнийн Их сургууль)

Жэй Турнер (Сайнт Луйс дэх Вашингтоны Их сургууль)

ГАРЧИГ

Талархал	5
Товчилсон үгийн жагсаалт	6
Үр дүн ба зөвлөмж.....	8
Танилцуулга.....	10
Хувилбарууд	11
Судалгааны арга аргачлалын тайлбар.....	11
Хэмжигдэхүүний талаар.....	13
Судалгааны үр дүн	13
Өртөлтийн хэмжээ	13
Эрүүл мэндийн нөлөөлөл	16
Дүгнэлт	22
Хавсралт А. Нарийвчилсан тайлбар, мэдээллийн эх үүсвэрүүд	23
Халаалтын хэлбэрүүд	23
Цахилгаан станцын утааны ялгаралтын хувилбарууд.....	28
Авто тээврийн хэрэгслийн утааны ялгаралтын хувилбарууд.....	29
Үр дүнгийн таамаглал ба тэдгээрийн эх үүсвэр	31
Хавсралт Б. Гадаад орчны агаарын чанарын бохирдлын хэмжээ	32
Гадаад орчны агаарын чанарын загварчлал.....	32
Гадаад орчны агаарын чанарын загварын үр дүнгүүд.....	35
Хавсралт В. Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ.....	38
Дулааны эх үүсвэрүүд, тамхидалт ба дотоод орчны агаарын бохирдлын загварчлал...	38
Гадаад орчны тоосонцорын нэвчилт.....	41
Дотоод орчны агаарын бохирдол	43
Хавсралт Г. Нийт өртөлтийн тооцоо	46
Эх үүсвэр	46
Өртөлтийн загвар.....	46
Хүн амд жинлэсэн өртөлт ба Хоногийн цагийн хуваарь	45
Хувилбар тус бүр дэх хүн амын бүлгийн өртөлт	51
Хавсралт Д. Эрүүл мэндийн ачаалал болон үр ашгийн тооцоо	52
Өнөөгийн байдал.....	52
Загвар ашигласан аргачлалын тайлбар.....	52
Цаг бус нас баралт ба Өвчлөлөөр алдсан амьдралын жилүүд	53
Харьцангуй эрсдэл	54
Уушгины сүрьеэгийн тооцоо.....	54
Шугаман бус өртөлтийн хариу үйлдэл.....	57

Эрүүл мэндийн хожуу үед илрэх нөлөөлөл.....	57
Зардлын үр ашиг.....	58
Хавсралт Е. Аргачлал болон өгөгдлийн хязгаарлагдмал талууд	59
Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ялгаралтын тооцоо	59
Агаарын чанарын загварын сонголт.....	59
Гадаад орчны агаарын чанарын өгөгдөл.....	59
Эрүүл мэндийн нөлөөлөл.....	60
Хотын өсөлтийн хувилбар.....	60
Тамхидалт	61
Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ	61
Аж үйлдвэрийн ялгаралт	61
Нүүрсний төрөл	61
Хавсралт Ё. Хүн ам ба эрүүл мэндийн урьдчилсан төлөв байдал.....	63
Хүн амын мэдээлэл	63
Өрхийн хэлбэрүүд.....	63
Өвчлөлийн суурь үзүүлэлт.....	65
Хавсралт Ж. Эрүүл мэндийн ачааллын нэмэлт хүснэгт.....	67
Номзүй.....	77

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгаанд АНУ-ын Берkeley хотын Агаарын хэмжилтийн баг мэргэжлийн дэмжлэг, зөвлөгөө өгч ажилласан ба судалгааны явцад Мариа Хернандээ, Ажай Пилларисэтти, Николас Лайм нар хамтран ажилласанд талархал илэрхийлье. Мөн Сарат Гуттикунда өөрийн боловсруулсан загварыг бидэнтэй хуваалцсанд талархалаа.

Мянганы Сорилтын Сангийн Эрчим хүч, Байгаль орчны төслийн үнэлгээ хийх ажлын хүрээнд Сошиал Импакт компанийн гүйцэтгэсэн айл өрхийн мэдээллийг ашиглах боломж олгосонд талархаж байна.

Энэхүү тайланд 2014 оны 2 дугаар сарын 7-ны өдөр ЭМШУИС-д зохиогдсон уулзалтанд оролцогсдын санал, зөвлөмжийг тусгасан болно.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Газар, Нийслэлийн Статистикийн Газар, Эрүүл Мэндийн Яамны харъяа Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв бидэнд хүн амзүйн болон эрүүл мэндийн мэдээлэл өгч дэмжин ажилласанд талархал илэрхийлье.

Монгол Улсын Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны захиалгаар Засгийн газрын тусгай сан болох Цэвэр Агаар Сангийн санхүүжилттэйгээр энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ.


ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААЖ	Алдагдсан Амьдралын Жил
АДЗЦХ	Амьсгалын Доод Замын Цочмог Халдвар
АНУ	Америкын Нэгдсэн Улс
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ДӨА	Дэлхийн Өвчлөлийн Ачаалал
ДӨА/ХЭҮ	Дэлхийн Өвчлөлийн Ачааллын Харьцуулсан Эрсдэлийн Үнэлгээ
ДТ	Дам Тамхидалт
ДЦС	Дулааны Цахилгаан Станц
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЗЦХЭ	Зүрхэнд Цус Хомсрох Эмгэг
м	метр
мкг	микрограмм
МСС	Мянганы Сорилтын Сан
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НЭМС	Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
ӨААЖ	Өвчлөлөөр Алдагдсан Амьдралын Жил
ӨАБИА-НАРИТ	Өрхийн Агаарын Бохирдлын Интерванци Арга
ТДАЖ	Тахир Дутуугаар Амьдарсан Жилүүд
УАБӨ	Уушгины Архаг Бөглөрөлтөт Өвчин
ХАНХ	Хүн Амд Ногдох Хэсэг
ЦБНБ	Цаг Бус Нас Баралт
ЦУОШГ	Цаг Уур Орчны Шинжилгээний Газар
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ЭМШУИС	Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
ЭХИС	Эрчим Хүчний Инженерийн Сургууль

CRA/GBD	Comparative Risk Assessment of the Global Burden of Disease
DALY	Disability Adjusted Life Year
ESP	Electrostatic precipitator
ICD	International Classification of Diseases
IF	Infiltration Factor
JICA	Japan International Cooperation Agency
GIS	Geographical Information System
NOAA HYSPLIT	National Oceanic and Atmospheric Administration Hybrid Single Particle Lagrangian Integrated Trajectory Model
NSPS	New Source Performance Standard
PAF	Population Attributable Fraction
PM	Particulate Matter
PTEF	Polytetrafluoroethylene
US EPA	United States Environmental Protection Agency
UN DESA	United Nations Department of Economic and Social Affairs
YLD	Years Lived with Disability
YLL	Years of Life Lost

ҮР ДҮН БА ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хотын хүн амын дунд нарийн ширхэглэгт тоосонцороос (PM2.5) үүдсэн өвчлөл нилээд хувийг эзэлдэг бөгөөд түүний өртөлтийн жилийн дундаж хэмжээ нь 70 мкг/м³ байгаагаас шалтгаалан хүүхдийн уушгины хатгалгаа (цаг бус нас баралт жилд ойролцоогоор 130 тохиолдол), насанд хүрэгчдийн зүрх судасны өвчлөл (цаг бус нас баралт жилд ойролцоогоор 1440 тохиолдол) зэрэг эмгэгүүд тэргүүлж байна. Утааны ялгаралыг бууруулах талаар авч хэрэгжүүлж буй одоогийн арга хэмжээнүүд нь дараагийн 10 жилд агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг хангалттай түвшинд хүртэл бууруулж чадахгүй болох нь доорх зурагт үзүүлсэнээр харагдаж байна (Зураг, Төлөв 2013).



Зураг. Үнэлгээ хийгдсэн дараагийн 10 жилийн агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн нөлөөлөл, хувилбар тус бүрээр. ӨААЖ/жил. Зөвхөн Хувилбар 2-т ӨААЖ буурч байна.

Улаанбаатар хотод агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийгдэх олон салбарыг хамарсан үйл ажиллагаа төлөвлөгдсөн хэдий ч өнөөгийн нөхцөл, цаашдын төлөв байдлаас дүгнэхэд хүн амын нарийн ширхэглэгт тоосонцорт (PM2.5) өртөх байдал нь нэмэгдэх хандлагатай байна. Айл өрхүүдэд ашиглагдаж буй нүүрсээр галладаг уламжлалт зуухны хэрэглээг бууруулж, бусад салбаруудад орчин үеийн шинэ дэвшилтэт аргуудыг амжилттай нэвтрүүлснээр өнөөгийн гадаад орчны агаарын бохирдлын хүн амын өртөлтийг 70 хүртэл хувиар бууруулах боломжтой юм (Хувилбар 1). Ийнхүү нарийн ширхэглэгт тоосонцорын өртөлтийн жилийн дундаж хэмжээг 45 мкг/м³ хүртэл бууруулсан ч энэ үзүүлэлт нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) агаарын чанарын зөвлөмж (10 мкг/м³) болон АНУ-ын үндэсний стандарт хэмжээнээс (12 мкг/м³) их хэвээр байх юм.

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг олон улсын жишигт хүртэл бууруулахын тулд айл өрхүүдийн хатуу түлшний (нүүрс, мод) хэрэглээг бүрэн халж, гадаад орчны бохирдуулагч эх үүсвэрүүдэд хатуу хяналт тавих шаардлагатай юм (Хувилбар 2). Ингэснээр хатуу түлшнээс үүдэлтэй агаарын бохирдол буурч, дам тамхидалтаас үүдэлтэй өртөлтийн эзлэх хувь нэмэгдэнэ. Энэ үед тамхины эсрэг үйл ажиллагааг улам эрчимжүүлэх шаардлагатай. Одоогоор зуухнаас гарч буй бохирдуулагчдыг хангалттай хэмжээгээр бууруулах боломжгүй тул айл өрхүүдийн халаалтыг хийн түлш, цахилгаан болон төвлөрсөн дулаан хангамжид бүрэн шилжүүлэх төлөвлөгөөг одооноос боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэхүү судалгаагаар бид олон салбарыг хамарсан нэгдсэн зохион байгуулалттай цогц арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж чадвал дараагийн 10 жилд агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг өнөөгийн түвшингөөс 25 хүртэл хувиар бууруулах боломжтой болохыг харууллаа. Харин илүү эрчимтэй, цогц арга хэмжээг авч амжилттай хэрэгжүүлж чадвал 2025 он гэхэд зөвхөн хүн амын эрүүл мэндийг хамгаалаад зогсохгүй, жилийн дундаж эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг одоогийнхоос даруй 60 орчим хувиар бууруулж чадахаар байна. Харин дээрх хугацаан дахь хүн амын өсөлтийг тооцоолвол 1 хүнд ногдох нөлөөлөл 70 орчим хувиар буурах юм.

Энэхүү судалгаагаар сүүлийн хоёр хувилбарт (Хувилбар 1, 2) агаарын бохирдлыг бууруулах зардлын дүнг тооцоогүй ба үүнийг бодлогын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн авч үзэх нь зүйтэй юм. Бидний ашигласан бүх хэмжилт, тооцоолол нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, туршилтаар батлагдсан аргууд бөгөөд техникийн хувьд боломжит, хялбар аргачлал юм. Иймд судалгааны багийн зүгээс өнөөгийн эрүүл мэндийн үндсэн нөлөөлөл болон судалгаагаар гарсан үнэлгээний дагуу Улаанбаатар хотын холбогдох байгууллагын удирдлагууд Хувилбар 2-т тусгагдсан арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн их агаарын бохирдолтой хотуудын нэг учраас иргэд, оршин суугчид, бодлого боловсруулагчдын хувьд агаарын бохирдол нь улам их санаа зовоосон, анхаарал хандуулах шаардлагатай асуудал хэвээр байсаар байна.

Цахилгаан станц, тээврийн хэрэгсэл, уурын зуух, бусад үйлдвэрлэлээс үүдсэн агаарын бохирдлын зэрэгцээ гэр хорооллын айл өрхүүдийн хатуу түлшний хэрэглээнээс үүдсэн бохирдол ихээр нэмэгдэж байна. Ихэнх ажиглагч, судлаачид утааны хэмжээг шаардлагатай түвшинд хүртэл бууруулах хэрэгтэй гэдгийг мэдэж байгаа хэдий ч удаан хугацааны турш бууруулах эсвэл хурдан хугацаанд бууруулах хувилбаруудын аль нь илүү үр дүнтэй вэ гэдгийг одоогоор тодорхойлж чадаагүй байна. Учир нь үүнийг тодорхойлоход эдийн засгийн хувьд зардал ямар байх, стратегийн зөв бодлого, чиглэлийг хэрхэн хэрэгжүүлэх зэрэг томоохон өөрчлөлтүүдийг цогцоор нь тооцох шаардлагатай юм.

Агаарын бохирдлоос үүдэн үзэгдэх орчин хязгаарлагдмал, хөрөнгийн үнэлэмж буурах, цаг уур өөрчлөгдөх зэргээс гадна хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх байдал нь хамгийн чухал асуудал юм. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах өөр боломжит стратегиудын үр нөлөөг харуулах зорилгоор судалгааны баг дараах асуултад хариулахыг зорилоо.

“2025 он гэхэд утааг багасгахтай холбогдуулан гэр хорооллын айл өрхүүдийн хэрэглэх зуух, түлшийг сайжруулж бусад салбарын үйл ажиллагаатай уялдуулснаар эрүүл мэндэд ямар үр нөлөө үзүүлэх вэ?”

ХУВИЛБАРУУД

Бид энэхүү судалгааг хийхдээ 2025 он хүртэл дараах гурван хувилбар тус бүрээр дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- **Төлөв 2013: Өнөөгийн төлөвлөлтөөр хүрэх үр дүн (Business as usual – 2013 оны 6 дугаар сарын байдлаар)** – Монгол улсын хэмжээнд 2013 оны 6 дугаар сарын байдлаар Улаанбаатар хотын утааг бууруулахаар авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бүх арга хэмжээ амжилттай хэрэгжихээр тооцсон. Үүнд: гэр хорооллын айл өрхүүдийн нүүрсээр галладаг зуухыг Мянганы Сорилтын Сангийн (МСС) сайжруулсан зуухаар бүрэн солих гэх мэт.
- **Хувилбар 1: Илүү дэвшилтэт технологи нэвтрүүлснээр хүрэх үр дүн** – Гэр хорооллын айл өрхүүдийг илүү сайжруулсан технологийн дэвшилтэт зуухаар бүрэн хангах гэх мэт бүх чиглэл, салбарт Төлөв 2013-аас илүү хурдацтай арга хэмжээ авах.
- **Хувилбар 2: Эрс шийдэмгий сайжруулалтаар хүрэх үр дүн** – Боломжит байдалд суурилсан эрүүл мэндийн үр ашгийг бий болгох ба айл өрхийн хатуу түлшний (нүүрс, мод) хэрэглээг бүрэн халах зэрэг бүх чиглэл, салбарт Хувилбар 1-ээс илүү эрс шийдэмгий өөрчлөлт хийх.

Хувилбар тус бүрийн хэмжилт болон тооцооны багц мэдээллийг Хавсралт А-д үзүүлэв.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Судалгаанд хэрэглэгдсэн мэдээллийн эх үүсвэр, тооцоо, аргачлалуудыг хавсралтаар үзүүлсэн бөгөөд Улаанбаатар хот төдийгүй бусад газарт хэрэглэгдэж байгаагүй хэд хэдэн төрлийн шинэ мэдээллийг ашиглан үнэлгээг боловсруулсан.

2012 онд Лим нарын, 2013 онд Бурнет нарын, 2014 онд Смит нарын судалгааны багийн боловсруулан хэвлүүлсэн “Дэлхийн Өвчлөлийн Ачааллын Харьцуулсан Эрсдэлийн Үнэлгээ – ДӨА/ХЭҮ” (Comparative Risk Assessment of the Global Burden of Disease – CRA/GBD) судалгааны аргачлалыг бид судалгаандаа ашигласан.

Агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн нөлөөллийг тодорхойлохдоо өртөлт – хариу үйлдлийн муруйг ашигласан. Энэ нь бохирдлын өртөлтийн тун өөрчлөгдөхөд тун тус бүрт эрүүл мэндийн нөлөөлөл хэрхэн өөрчлөгдөж байгааг ялгаатай байдлаар тодорхойлдогоруу давуу юм. Улаанбаатар хотод хийгдсэн энэхүү үнэлгээ нь дэлхийд анх удаа хийгдэж буй бөгөөд бодлогын үр дүнг үнэлэхэд ашиглагдсанаараа давуу талтай (олон хувилбарт) шинэ судалгаа боллоо.

ДӨА/ХЭҮ судалгаагаар олон орны эрдэмтэн судлаачид агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн нөлөөллийг үнэлэх талаар өргөн хүрээтэйгээр ажилласан байдаг. Ийнхүү агаарын бохирдол болон түүнээс үүдэлтэй үндсэн таван төрлийн өвчлөлийн хоорондын тоон хамаарлыг тогтоосон.

5 хүртэл насны хүүхэд Уушгины хатгалгаа буюу амьсгалын доод замын цочмог халдвар (АДЗЦХ) – 2 дугаарт эрэмбэлэгдсэн

Насанд хүрэгчид Зүрхэнд цус хомсрох эмгэг (ЗЦХЭ) – 1 дүгээрт эрэмбэлэгдсэн

Тархи, судасны эмгэг (шигдээс) – 3 дугаарт эрэмбэлэгдсэн

Уушгины архаг бөглөрөлтөт өвчин (УАБӨ) – 17 дугаарт эрэмбэлэгдсэн

Уушгины хавдар – 18 дугаарт эрэмбэлэгдсэн

Эдгээр таван өвчлөлөөс гурав нь Монгол улсын хувьд ихээхэн чухал ач холбогдолтой юм. Дэлхийн Өвлөлийн Ачаалалын (ДӨА) судалгаагаар Монгол улсын өвчлөлийн ачааллыг 2010 оны байдлаар нь жагсаахад ЗЦХЭ, АДЗЦХ, тархи, судасны эмгэг эхний гурван байранд эрэмбэлэгдсэн байна. Зөвхөн энэхүү гурван эмгэг нь тухайн жилийн алдагдсан амьдралын жилийн (ААЖ) гуравны нэгийг бүрдүүлж байна (Эрүүл Мэндийн Хэмжилт, Үнэлгээний Хүрээлэн, 2010)¹. Агаарын бохирдол нь дээрх өвчлөлүүдийн цорын ганц шалтгаан биш боловч судалгааны үр дүнгээс харахад үндсэн шалтгаануудын нэг болох нь харагдаж байна.

Хэдийгээр агаарын бохирдлоос үүдэлтэй сүрьеэ², бага жинтэй төрөлт зэрэг олон төрлийн эмгэгүүд байдаг боловч ДӨА/ХЭҮ судалгааны үр дүнгээр шууд хамааралтай эсэх нь нотлогдоогүй байна. Тиймээс эдгээр өвчлөлүүдийн талаар цаашид илүү дэлгэрүүлэн судалж, агаарын бохирдлоос үүдэлтэй эмгэгүүдийг нарийвчлан тогтоож, өвчлөлийн талаарх нотолгоог улам батжуулах шаардлагатай байна. Иймээс бид судалгаандаа зөвхөн дээр дурдсан таван өвчлөлийг сонгон авсан.

Энэхүү судалгааны бас нэг шинэлэг тал нь үнэлгээг зөвхөн гадаад орчны эсвэл дотоод орчны бохирдолд суурилах бус гадна болон дотор орчны ялгаралт, тэдгээрийн харилцан үйлчлэлийг тооцсон явдал юм. Жишээлбэл гадаад орчны агаарын бохирдол амьдрах орчинд хэдий хэмжээгээр нэвтрэн орж байгааг үнэлэх гэх мэт үзүүлэлтийг тооцсон хүн амын нийт өртөлтийг үнэлсэн. Эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг тооцоходоо агаарын бохирдлыг тодорхой байршилгүй нийт хэмжээгээр нь авах бус бохирдолд өртөж буй хүмүүс өдрийн турш өнгөрөөж буй газруудаар нь тодорхойлсноор хаана утааны ялгаралтыг бууруулснаар илүү үр дүнд хүрч болохыг бодитоор харуулж чадсан юм. Энэ нь хэдийгээр бид анхнаасаа төлөвлөөгүй байсан хэдий ч дотоод орчны агаарын бохирдлын эх үүсвэр болох дам тамхидалтыг судлахад хүргэсэн юм. Илүү дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт Г-д үзүүлэв.

Улаанбаатар хотод шинээр хийсэн хэмжилтүүд:

- Нөлөөллийг илүү үнэн зөв гаргах зорилгоор хүн амзүйн болон эрүүл мэндийн цаашдын төлөв байдлыг өвчлөлийн төрлөөр нь нарийвчлан гаргасан болно. Дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт Ё-д үзүүлэв.
- МСС-ийн сайжруулсан зуухны төслийн нэг хэсэг болох зуухнаас ялгарах бохирдлыг тогтоох болон бусад өрхийн хүчин зүйлсийг үнэлсэн Сошиал Импакт компани судалгааны үр дүнг ашиглалаа (Сошиал Импакт, 2013).
- Мөн энэ судалгаанд ашиглах зорилгоор МСС-ийн сайжруулсан зуухны хэрэглээ болон гэрт амьдарч буй айл өрхүүдийн дотоод орчны агаарын бохирдлын агууламжийг хэмжсэн.
- Энэхүү судалгаанд ашиглах зорилгоор боловсруулсан хувилбар тус бүрийн гадаад орчны агаарын бохирдлыг тооцсон.

¹ Хавсралт Д-г үзнэ үү.

² Агаарын бохирдол болон сүрьеэ өвчний хамаарлын талаарх судалгаа бусад өвчинтэй харьцуулахад хангалттай биш байна. Иймд бид хэдийгээр сүрьеэ өвчний талаарх тоо баримтыг хавсралтад дурдсан боловч судалгааны тооцоонд оруулаагүй болно.

ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ТАЛААР

Шаталтаас үүссэн агаар бохирдуулагч нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5) нь хүний уушгинд гүн нэвтрэн орж, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг үндсэн бохирдуулагч юм. Агаар бохирдуулагч бусад бодисуудтай харьцуулахад нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) эрүүл мэндийн нөлөөлөл харьцангуй их судлагдсантай холбоотойгоор түүний эрүүл мэндийн талаарх лавлагаа элбэг байдаг. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт-хариу үйлдлийн муруйн хамааралд үндэслэн тохиолдох өвчлөлүүдийг илрүүлэх боломжтой учир бид нарийн ширхэглэгт тоосонцорыг (PM2.5) үндсэн бохирдуулагчаар сонгон боловсруулалтаа хийлээ.

Судалгааны баг эрүүл мэндтэй холбоотой үр дүнг гурван хувилбар тус бүрээр өвчний төрөл болон насны бүлгээр нь ялган цаг бус нас баралт ба өвчлөлөөр алдсан амьдралын жилүүдийг (ӨААЖ) (Disability adjusted life years – DALY) тус тус тооцсон. ӨААЖ нь олон улсад эрүүл мэндийн судалгаанд хэрэглэгддэг насны бүлэг тус бүрт хамаарах цаг бус нас баралт болон тухайн өвчлөлийн хүнд хөнгөн байдлыг давхар харгалзан тооцдог хэмжигдэхүүн юм. Агаарын бохирдлоос үүдэлтэй ӨААЖ болон бусад эрсдэлт хүчин зүйлсийг тооцохдоо дараах хоёр хэмжигдэхүүнийг авч үздэг.

ААЖ – алдагдсан амьдралын жилүүд (YLL – years of life lost) гэдэг нь дэлхийн хамгийн өндөр дундаж настай (~86) харьцуулсан цаг бус нас баралт

ТДАЖ – тахир дутуугаар амьдарсан жилүүд (YLD – years lived with disability) гэдэг нь өвчин эмгэг, осол гэмтлийн улмаас үүсэх эрүүл мэндийн нөхцлийг тухайн эмгэг тус бүрт тооцсон амьдарсан жилүүд

Дээрх хоёр хэмжигдэхүүний нийлбэр нь өвчлөлөөр алдсан амьдралын жилүүд болно.

$$\text{ӨААЖ} = \text{ААЖ} + \text{ТДАЖ}$$

Иймд ӨААЖ нь өвчлөл тус бүрээс (уушгины хатгалгаа, хавдар гэх мэт) үүдэлтэй эрүүл мэндийн нөлөөлөл болон насны бүлэг тус бүрт (хүүхэд, насанд хүрэгчид гэх мэт) тооцсон нэгдмэл хэмжигдэхүүн юм. ӨААЖ нь эдийн засгийн тооцоо хийхэд хамгийн тохиромжтойд тооцогддог. Жишээлбэл эрүүл мэндийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг тооцон, эрүүл байхын үр ашгийг нэг ам.долларт шилжүүлэн тооцдог. Илүү дэлгэрэнгүйг Хавсралт Д-д үзүүлэв.


СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны хүрээнд нэгдүгээрт, одоогийн байгаа агаарын бохирдлын түвшинд (Суурь түвшин – Baseline) нийслэл хотын иргэдийн нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийг үнэлэн улмаар агаарын бохирдлын түвшинг бууруулах гурван хувилбар тус бүрээр тооцон эрүүл мэндийн ачааллын үзүүлэлтүүдийг үнэллээ.

ӨРТӨЛТИЙН ХЭМЖЭЭ

Энэхүү судалгаанд нийт өртөлтийг тооцохдоо гадаад болон дотоод орчны агаарын бохирдлын агууламж дээр үндэслэсэн бөгөөд хүн амзүйгээр нь ялган өдөрт хэдэн цагийг хаана өнгөрүүлдэг зэрэг үзүүлэлтүүдтэй нь холбон судалсан. Дотоод орчны агаарын бохирдлын агууламжийг тооцохдоо тамхи таталт, зуухнаас шүүрч ялгарах утаа болон

сууцны төрлөөс хамааран гадаад орчны агаараас гэр лүү нэвтрэх агаарын бохирдол, нарийн ширхэглэгт тоосонцорыг (PM2.5) тус тус тооцлоо³. Гадаад орчны агаарын бохирдлыг загварчлалын аргаар тооцсон бөгөөд дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт Б-д үзүүлэв. Дотоод орчны агаарын бохирдлын агууламжийн тооцоог Хавсралт В-д, нийт өртөлтийн хэмжээг цагаар нь тооцож гаргасныг Хавсралт Г-д тус тус үзүүлэв.



Зураг 1. Хүн амд жинлэсэн нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жилийн дундаж хэмжээ. Суурь түвшин болох 2014 оноос 2024 он хүртэл гадаад орчны агаарын бохирдлын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийн дундаж хэмжээг хувилбар тус бүрээр нийслэлийн нийт хүн амд жинлэсэн дүнг шугаман байдлаар үзүүллээ⁴.

Зураг 1-т судалгааны явцад хэмжсэн хувилбар тус бүр дэх гадаад орчны агаарын бохирдлын агууламжид үндэслэн хүн амын өртөлтийн хэмжээ, эрүүл мэндийн нөлөөллийн үр дүнг тооцон харуулсан. Үүнд цаашид бий болох боломжтой агаарын бохирдлын эх үүсвэрүүдийг тооцоогүй болно. Дээрх зургаас харахад Хувилбар 1-ийг хэрэгжүүлэхэд хэдийгээр гадаад орчны агаарын бохирдлын агууламж буурч байгаа боловч Хувилбар 2-той харьцуулахад агаарын бохирдлын агууламжийг олон улсын стандартад нийцэхүйц хэмжээнд хүргэх боломжгүй нь харагдаж байна.

Хүснэгт 1-т Судалгааны ажлын эцсийн шатанд хийгдсэн хүн амын агаарын бохирдлын өртөлтийн жилийн дундаж хэмжээг хувилбар тус бүрт орчны болон дам тамхидалтын

³ Ажлын байран дахь өртөлтийн хэмжээг энэ судалгаанд тооцоогүй болно.

⁴ 2014 оны загварт олон төрлийн хүчин зүйлсийг тооцсон ба үүнд загварын бус эх үүсвэрүүд, ерөнхий туршилтын загвар зэргийг тооцсон. 2024 оны загварт нийт хүн амд жинлэсэн жилийн дундаж өртөлтийг 10 мкг/м³ хүртэл нарийн ширхэглэгт тоосонцорт (PM2.5) харьцуулан тооцож авсан ба бусад үйлдвэрлэл, замын болон салхинаас үүсч буй тоосонцоруудыг энэ загварт оруулаагүй болно. Энэхүү 10 мкг/м³ дахь өртөлтийн хэмжээг 2024 онд тооцсон хувилбар тус бүрийн өртөлтөд шилжүүлэн үнэллээ.

өртөлтийн хувиар үзүүллээ. Нийслэлийн иргэдийг амьдрах сууцны төрлөөр нь ангилан хувилбар тус бүрээр харьцуулсан дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт Г-д үзүүлэв.

Хүснэгт 1. Нийт хүн амын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт

	Жилийн дундаж (мкг/м ³)	Дотоод орчны агаарын өртөлт (хувиар)	Гадаад орчны агаарын өртөлт (хувиар)	Дам тамхидалтын өртөлт (хувиар)
Суурь түвшин – Нийт хүн ам	68.0	71.9	7.3	20.8
Гэрт оршин суугчид	78.6	75.8	6.2	18.0
Амины байшинд оршин суугчид	78.0	75.2	6.7	18.1
Орон сууцанд оршин суугчид	57.0	66.7	8.5	24.8
Төлөв 2013 – Нийт хүн ам	74.7	71.9	9.2	18.9
Гэрт оршин суугчид	85.8	75.7	7.8	16.5
Амины байшинд оршин суугчид	83.0	74.5	8.5	17.0
Орон сууцанд оршин суугчид	69.8	69.9	9.8	20.3
Хувилбар 1 – Нийт хүн ам	46.9	62.7	6.8	30.5
Гэрт оршин суугчид	70.3	75.5	4.4	20.1
Амины байшинд оршин суугчид	58.1	67.8	6.2	26.0
Орон сууцанд оршин суугчид	38.4	55.3	7.9	36.8
Хувилбар 2 – Нийт хүн ам	21.5	29.8	4.4	65.8
Гэрт оршин суугчид	23.5	35.9	4.0	60.1
Амины байшинд оршин суугчид	21.0	28.1	4.5	67.4
Орон сууцанд оршин суугчид	21.2	28.6	4.6	66.8

Суурь түвшин: Нийслэлийн хүн амын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийн жилийн дундаж хэмжээ одоогийн байдлаар 68.0 мкг/м³ (МСС-ийн сайжруулсан зуухаар бүрэн сольсон тохиолдолд) байна. Нийт өртөлтийн ойролцоогоор 71.9% нь дотоод орчинд, 7.3% нь гадаад орчноос үүдэлтэй байна. Гэртээ тамхи татсаны улмаас үүссэн дам тамхидалтын өртөлт нь дээрх үзүүлэлтүүдтэй эн зэрэгцэх хэмжээнд буюу 20.8% байгаа бөгөөд үүнд зөвхөн идэвхтэй тамхи татагчдаас гадна дам тамхидалтад өртөгсөд буюу хүүхэд, насанд хүрэгчид мөн адил багтаж байна. Эндээс дүгнэхэд дотоод орчны бохирдол нь эрүүл мэндэд хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн гэр, болон байшинд оршин суугчдын өртөлт нь төвлөрсөн халаалттай орон сууцанд оршин суугчдын өртөлттэй харьцуулахад өндөр байна.

Төлөв 2013: Дараагийн 10 жилд дотоод болон гадаад орчны үүсвэрүүд болон тамхи таталтын харьцаа хэвээр байх ба өртөлтийн хэмжээ одоо байгаа түвшингөөс бага зэрэг өөрчлөгдөх хэдий ч хүн амын өсөлттэй холбоотойгоор гадаад орчны агаарын бохирдлын хэмжээ ихэснэ. Иймд агаарын бохирдол болон түүнээс үүдэлтэй эрүүл мэндийн нөлөөлөл нэмэгдэнэ.

Хувилбар 1: Энэ хувилбарын тооцооны дагуу гэр болон байшинд оршин суугчдад утаа бага ялгаруулдаг илүү дэвшилтэт зуух түгээх, халаалтын зуухыг 70%, цахилгаан станцуудын утааны ялгаралтыг шинэчилж 50%, тээврийн хэрэгслийн утааг 80% тус тус бууруулж, төвлөрсөн халаалттай орон сууцанд амьдрах иргэдийн тоог 3% нэмэгдүүлж, шинээр үүсэх эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчээр хангах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр гадаад орчны утааны ялгаралтыг багасгаж агаарын бохирдлын өртөлт 47%-аар буурна. Энэ үед дотоод үүсвэрүүдээс үүдэлтэй өртөлт харьцангуй өндөр байх боловч дотоод (гаднаас нэвтрэх замаар дотор орсон) болон гадаад үүсвэрүүдээс үүдэлтэй өртөлт буурснаар агаарын чанар бодитойгоор сайжирна. Ингэснээр тамхи таталттай холбоотой өртөлтийн эзлэх хувь ихэснэ. 2013 оноос Улаанбаатар хотод хэрэгжиж эхэлсэн олон нийтийн газар тамхи татахыг хориглосон зохицуулалт нь өндөр үр дүнтэй байх юм. Нийт хүн амын дунд тамхидалтын эсрэг эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх шаардлагатай.

Хувилбар 2: Энэ хувилбарын дагуу агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр илүү эрчимтэй үйл ажиллагаа явуулснаар хүн амын эрүүл мэндийн агаарын бохирдлын нөлөөлөлд өртөх байдал 71.2%-аар багасна. Хувилбар 2-т гэр хорооллын айл өрхүүдийг хийн түлшинд бүрэн шилжүүлэх эсвэл төвлөрсөн халаалтад холбох, бүх халаалтын зуухыг ашиглалтаас гаргах, тээврийн хэрэгслийн утааны ялгаралтыг 25%-аар бууруулах зэрэг эрс шийдэмгий арга хэмжээнүүдийг тусгасан болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН НӨЛӨӨЛӨЛ

Агаарын бохирдлын эрүүл мэндийн нөлөөллийг нотолгоонд тулгуурлан, хэтийн төлөв болон эрүүл мэндийн ачааллыг тооцох аргачлалын задаргааг Хавсралт Д-ээс үзнэ үү⁵. Бид Улаанбаатар хотын өнөөгийн агаарын бохирдлын өртөлт эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг тогтоож, улмаар Төлөв 2013-аар дараагийн 10 жилд тухайн үзүүлэлт

⁵ Эрүүл мэндийн суурь үзүүлэлтүүдийг бид Эрүүл мэндийн яамнаас гаргасан мэдээллийг олон улсын Эрүүл Мэндийн Хэмжилт, Үнэлгээний Хүрээлэнгээс (Institute for Health Measurement and Evaluation – IHME) гаргадаг дүн мэдээтэй харьцуулсан. Энэхүү олон улсын мэдээллийн сан нь Дэлхийн Өвчлөлийн Ачааллыг тооцох аргачлалын дагуу улс орнуудын эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг нэгтгэн гаргадаг юм. Хавсралт E–д дэлгэрэнгүйг үзүүлэв.

хэрхэн өөрчлөгдөх, мөн бохирдлын эсрэг эрчимтэй нэмэлт арга хэмжээнүүд авснаар (Хувилбар 1, 2) эрүүл мэндэд нөлөөлөх байдлыг тус тус дүгнэлээ.

Суурь түвшин: Улаанбаатар хотын агаарын бохирдол нь өвчний үндсэн шалтгаан болж Хүснэгт 2-ын эхний баганад үзүүлсэнчлэн цаг бус нас баралт болон ӨААЖ-д нөлөөлж байна. Зураг 2-т өвчлөлийн бүтцийг харуулсан бөгөөд үүнд цаг бус нас баралтад зүрх судасны өвчин (зүрхэнд цус хомсрох эмгэг, шигдээс) давамгайлж байгаа бол ӨААЖ-д хүүхдийн уушгины хатгалгаа буюу АДЗЦХ давамгайлж байна.

Өвчлөлийн эрсдэлт хүчин зүйлсийг тооцох өөр нэг арга нь “хүн амд ногдох эрсдэлийн хэсэг – ХАНХ” (pollution attributable risk fraction – PAF) буюу тухайн хүн амд эзлэх өвчлөлийн хувийг тооцох юм. Хүснэгт 3-т дурдсан үндсэн таван өвчлөлийн ХАНХ-ийг хувилбар тус бүрээр дараагийн 10 жилд гарах өөрчлөлтийг үзүүллээ. Суурь түвшинд ХАНХ-д зүрхний шигдээс 42%, уушгины архаг бөглөрөлтөт өвчин 17% байна. Эндээс дүгнэхэд агаарын бохирдлыг амжилттай бууруулж чадвал тухайн өвчлөлүүдийн эрсдлийг төдий хэмжээгээр бууруулах боломжтой юм.


Хүснэгт 2. Цаг бус нас баралт болон ӨААЖ, хувилбар тус бүрээр

	2014 – 2024 онд өссөн дүнгээр, бодит тоо (1000 хүн амд)	2014 оны нэг жилийн хугацааны дүн, бодит тоо (1000 хүн амд)	2024 оны нэг жилийн хугацааны дүн, бодит тоо (1000 хүн амд)
Цаг бус нас баралт			
Төлөв 2013	16,200 (10.1)		1,710 (0.92)
Хувилбар 1	14,400 (9.0)	1,250 (0.92)	1,340 (0.72)
Хувилбар 2	11,600 (7.4)		580 (0.31)
ӨААЖ			
Төлөв 2013	510,000 (310)		54,000 (29)
Хувилбар 1	440,000 (270)	38,000 (28)	40,000 (22)
Хувилбар 2	340,000 (220)		15,400 (8.3)


Хүснэгт 3. Агаарын бохирдлоос үүдэлтэй үндсэн таван өвчлөлийн хүн амд ногдох хэсгийг (ХАНХ) тооцсон дүн (%), хувилбар тус бүрээр.

	Суурь түвшин (2014)	Төлөв 2013 (2024)	Хувилбар 1 (2024)	Хувилбар 2 (2024)
Уушгины хавдар	19.5	21.2	13.6	4.3
ЗЦХЭ	18.8	19.7	15.3	6.8
Шигдээс	41.7	42.6	37.2	18.0
АДЗЦХ (0-4 нас)	32.0	34.7	21.1	4.6
УАБӨ	16.6	17.8	12.0	4.2

Суурь түвшин дэх нас баралт (2014)




Суурь түвшин дэх ӨААЖ (2014)



Зураг 2. Улаанбаатар хотын агаарын бохирдлоос үүдэлтэй цаг бус нас баралт (зүүн) болон ӨААЖ-ийн (баруун) өвчлөлийн бүтэц.

Төлөв 2013: Төлөв 2013-т дараагийн 10 жилд эрүүл мэндийн нөлөөлөл нь ӨААЖ-ийн хэмжилтийн дагуу аажмаар нэмэгдэнэ (Зураг 3). Энэ хугацаанд агаарын бохирдлын өртөлт бага хэмжээгээр аажим нэмэгдэх (Хүснэгт 1) боловч энэхүү нөлөөлөл нь дараагийн 10 жилд 35%-аар өсөх хүн амын өсөлттэй холбоотойгоор нэмэгдэх юм (дэлгэрэнгүйг Хавсралт Ё-с үзнэ үү). Хүснэгт 3-т үзүүлсэнчлэн агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлийн ХАНХ-ийн хувь 2024 онд суурь түвшинтэй харьцуулахад өссөн дүнтэй байна.




Зураг 3. Үнэлгээ хийгдсэн дараагийн 10 жилийн агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн нөлөөлөл, хувилбар тус бүрээр: ӨААЖ/жил. Зөвхөн Хувилбар 2-д ӨААЖ буурч байна.

Хувилбар 1: Зураг 3-т дараагийн 10 жилд тодорхой зохион байгуулалттай арга хэмжээг авч хэрэгжүүлснээр агаарын бохирдлын хэмжээ багасч жилийн эрүүл мэндийн нөлөөлөл Төлөв 2013-тэй харьцуулахад аажмаар буурч байгаа нь харагдаж байна. Зураг 4-т үзүүлснээр Хувилбар 1-ийг амжилттай хэрэгжүүлснээр цаг бус нас баралт нийт 2000 гаруй нэгжээр буурна. Зураг 5-т үзүүлснээр 5 хүртэл насны хүүхдийн уушгины хатгалгаанаас үүдэлтэй ӨААЖ багасах төдийгүй насанд хүрэгчдэд ч мөн адил эрүүл мэндийн эерэг нөлөө үзүүлэхээр байна. Хувилбар 1 нь өвчлөлийн хэмжээний бууралтаар Төлөв 2013-тай харьцуулахад илүү үр дүнтэй байгаа хэдий ч Суурь түвшинтэй харьцуулахад жилийн хүн амд жинэлсэн эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бодитоор бууруулж чадахгүй байна. Өөрөөр хэлбэр энэ нь зөвхөн хүн амын өсөлтийн түвшинд дүйцэхүйц хэмжээнд байгаа юм.


Хүснэгт 3-т үзүүлсэнчлэн агаарын бохирдлоос үүдэлтэй өвчлөлийн ХАНХ-ийн хувь 2024 онд суурь түвшинтэй харьцуулахад буурна. Ийнхүү ХАНХ-д зүрхний шигдээс 37%, уушгины архаг бөглөрөлтөт өвчин 12% болно.

Цаг бус нас баралтыг Төлөв 2013-тай харьцуулахад,
2014-2024



Зураг 4. Үнэлгээ хийгдсэн хугацаан дахь Хувилбар 1, 2-ын үеийн цаг бус нас баралтын тооцоог өссөн дүнгээр Төлөв 2013-тэй харьцуулсан дүн. Хувилбар 2 нь Хувилбар 1-тэй харьцуулахад нас баралтыг 2.6 дахин бууруулна.


ӨААЖ-ийг Төлөв 2013-тай харьцуулахад,
2014-2024



Зураг 5. Үнэлгээ хийгдсэн хугацаан дахь Хувилбар 1, 2-ын үеийн ӨААЖ-ийн тооцоог өссөн дүнгээр Төлөв 2013-тай харьцуулсан дүн. Хүүхдийн АДЗЦХ илүү буурсан байна.

Хувилбар 2: Айл өрхүүдийн хэрэглээнээс хатуу түлшний зуухыг бүрэн халах гэх мэт бохирдолд илүү эрчимтэйгээр хяналт тавьж тодорхой зохион байгуулалттай арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлснээр Хувилбар 1-тэй харьцуулахад эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл Суурь түвшинөөс 60%-аар буурах юм.

Зураг 5-г үзүүлснээр хувилбар тус бүрийн хэрэгжилт нь хүүхдийн уушгины хатгалгаа болон насанд хүрэгчдийн зүрх судасны өвчлөлийн бууралтад хамгийн ихээр нөлөөлнө.



Зураг 6. Үнэлгээний хугацаан дахь хотын хүн амын өсөлтийн хандлага болон нэг хүнд ногдох ӨААЖ-ийн тооцоо, хувилбар тус бүрээр. 2014 оныг 100%-д тооцов.

Энэхүү үнэлгээний үр дүнг бодит тоон утгаар илэрхийлэхээс гадна нэг хүнд ногдох хувиар илэрхийлэх нь илүү оновчтой юм (Хүснэгт 2). Зураг 6-д судалгааны хугацаан дахь хүн амын өсөлтөд тулгуурлан нэг хүнд ногдох ӨААЖ-ийн цаашдын хандлагыг харуулсан бөгөөд үүнд Улаанбаатар хотын хүн ам 2014 онд 1,4 сая байсан бол 2024 онд 1,9 саяд хүрч өсөхөөр тооцсон. Ийм нөхцөлд нэг хүнд ногдох Төлөв 2013 ерөнхийдөө өөрчлөгдөхгүй нэг түвшинд байхаар ажиглагдаж байгаа бол Хувилбар 1-ийн хувьд эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл хүн амын өсөлттэй ижил хувиар буурч байгаа бол Хувилбар 2-ыг хэрэгжүүлснээр нэг хүнд ногдох эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл мэдэгдэхүйц хэмжээнд буурч байгаа нь харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаа нь нийт хүн амын шилжилт хөдөлгөөн, өрхийн ам бүлийн тоо, сууцны төрөл, эрүүл мэндийн байдал, нийслэлийн гадаад болон дотоод орчны бохирдлын 2014-2024 оны төлөвийг харуулсан гэх мэт олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг нэгтгэн, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр боловсруулагдсан үнэлгээ юм. Дээрх боловсруулсан мэдээллүүдийг нэгтгэн олон улсад ашиглагдаж буй өвчлөлийн төрөл зүйлээр нь өртөлт-хариу үйлдлийн муруйг ашиглан эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг гаргасан. Эдгээр мэдээллүүдийг цуглуулсан эх сурвалжууд нь өөр хоорондоо зөрүүтэй байсан зэргээс шалтгаалан бид цуглуулсан мэдээллээ дахин нягталж, бодит зөвийг нь сонгож авах шаардлагатай тулгарч байсан. Тиймээс бид эцсийн үр дүнгийн хэсэгт бодит таамаглал дэвшүүлж чадаагүй боловч Хавсралт Д-д хязгаарлагдмал талуудаа дурдсан болно.

Хэдийгээр цуглуулсан өгөгдөл, мэдээллүүд нь харилцан адилгүй дүнтэй байсан боловч бидний жил жилээр тооцон гаргасан цаг бус нас баралт болон ӨААЖ-ийн тоон үзүүлэлтүүдэд их зөрүүтэй өөрчлөлт орохгүй гэж бид үзэж байна.

Түүнчлэн тоон үзүүлэлтүүдийн зөрүү нь хувилбар тус бүрийн эрүүл мэндийн сөрөг нөлөөллийн үзүүлэлтүүдийн ялгааг илтгэхэд чиглэсэн юм. Улаанбаатар хотын агаарын бохирдлын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийн дундаж хэмжээ олон улсын стандарт түвшингөөс олон дахин хэтэрсэн байна. Хэрвээ ямар нэгэн эрс шийдэмгий цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол дараагийн 10 жилд энэ хэмжээ нь аажмаар ихсэх ба эрүүл мэндийн нийт нөлөөллийн нэг хүнд ногдох хувь мөн адил нэмэгдэх болно.

Судалгааны ажлын хүрээнд төлөвлөсөн (Хувилбар 1) агаарын бохирдлын агууламжийг тодорхой хэмжээнд зохицуулалттай бууруулах багц арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлснээр нэг хүнд ногдох ӨААЖ-ийг 25%-аар бууруулж байгаа ч олон улсын стандартаас мөн л өндөр байхаар байна. Судалгааны хүрээнд төлөвлөсөн (Хувилбар 2) илүү эрс шийдэмгий арга хэмжээ авах хувилбар нь айл өрхүүдийн хатуу түлшний хэрэглээг бүрэн халах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр судалгааны тооцооллын түвшинд эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг 60%, түүний нэг хүнд ногдох хувь хэмжээг 70%-аар тус тус бууруулж өртөлтийн түвшинг олон улсын жишигт нийцүүлэх боломжтойг харууллаа.

Судалгааг гүйцэтгэх ажлын даалгаварт дээрх хувилбар тус бүрийн агаарын бохирдлыг бууруулах зардлын тооцоог оруулаагүй бөгөөд үүнийг тооцох нь стратеги бодлогын хүрээнд авч хэлэлцэх асуудал юм. Судалгааны багийн зүгээс дээрх хувилбар тус бүрт тооцох хэмжилтүүд нь техникийн хувьд хэрэгжүүлэх боломжтой, бусад улс орнуудад хэрэглэгддэг аргачлал гэдгийг онцлон хэлэх нь зүйтэй. Өнөөгийн бий болоод буй эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл, энэхүү судалгааны үр дүнгээс харахад эрс шийдэмгий үйл ажиллагаа явуулж нөлөөллийг бууруулах шаардлага тулгарч буйг харуулж байгаа бөгөөд бидний зүгээс Улаанбаатар хотын удирдлага, бодлого боловсруулагчдад энэхүү асуудлыг анхааралдаа авч илүү эрчимтэй, дорвитой үйл ажиллагаа явуулах шаардлагатай байгааг анхааруулж байна. Ингэхдээ дэлхийн бусад улс орнуудын туршлагаас суралцан хэрэгжүүлэх хэрэгтэй бөгөөд үүний нэг тод жишээ нь 1950-аад оны үед их хэмжээний бохирдолтой байсан Лондон хот өрхийн хэрэглээнд нүүрс ашиглахыг бүрэн хориглох зэрэг шат дараалсан бодлогыг амжилттай авч хэрэгжүүлснээр өнөөдөр дэлхийн цэвэр хотуудын нэг болж чадсан явдал юм.

ХАВСРАЛТ А.

НАРИЙВЧИЛСАН ТАЙЛБАР, МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭРҮҮД

Агаарын чанарыг сайжруулах одоогийн болон ирээдүйд хэрэгжүүлэх арга хэмжээ, айл өрхүүдийн түлшний ашиглалт, түүнчлэн бусад агаар бохирдуулагч эх үүсвэрүүд тухайлбал цахилгаан станц, тээврийн хэрэгслүүд зэргийг холбон тооцохгүйгээр агаарын бохирдлоос хамаарах эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг үнэлэх боломжгүй юм. Бид хувилбар тус бүрийг тооцоог хийхдээ салбарын мэргэжилтнүүдтэй шат дараалсан ярилцлага хийж тэдгээр хүмүүс сүүлийн үед маш хурдацтайгаар өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээ, шаардлага болон агаарын бохирдлын асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжуудын талаар өөрсдийн бодлоо илэрхийлснийг тусгасан. Мөн дээрх ярилцлагуудад үндэслэн хувилбар тус бүрийг 2014 оны 1 дүгээр сараас эхлэн дараагийн 10 жилийн хугацаанд тооцож боловсруулахаар тогтсон болно. Судалгааны суурь түвшин болон өнөөгийн халаалт, цахилгаан станцуудын ажиллагаа, авто тээврийн хэрэгслүүдийн талаарх мэдээллийг засгийн газраас гаргасан тайлан мэдээ болон сүүлийн үед хэвлэгдэн гарсан эрдэм шинжилгээний өгүүллэгүүд зэргээс авч ашигласан бөгөөд Төлөв 2013-ыг засгийн газраас хэрэгжүүлж буй бусад төслүүдийн үр дүн, зөвлөмж болон судалгааны багийн гишүүдийн саналын дагуу боловсруулсан. Хувилбар 1, 2-т Төлөв 2013 дээр дурдсан 3 үндсэн бохирдуулагч эх үүсвэрт илүү дэвшилтэт технологи нэвтрүүлэх болон эрс шийдэмгий сайжруулалт хийснээр агаарын чанарт хэрхэн нөлөөлөх байдлыг тооцож үнэлсэн.

Суурь түвшин болон хувилбар тус бүрт хийгдэхээр тусгагдсан үйл ажиллагаа нь өрхийн орон сууц болон зуухны төрөл, гадаад ба дотоод орчны агаар дахь тоосонцорын агууламжаар үнэлэгдэнэ. Судалгаанд нийт өртөлтийг насанд хүрэгчид болон хүүхэд гэж тусад нь тооцсон бөгөөд агууламж, өртөлт, эрүүл мэндийн ачааллын үнэлгээний аргуудыг хавсралтуудад тодорхой тусгасан болно.

Халаалтын хэлбэрүүд⁶

Судалгаанд Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийг сууцны төрлөөр нь гэр, байшин, орон сууц гэсэн гурван үндсэн бүлэг болгон үзэж нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) эх үүсвэр болон өртөлтийг тооцсон.

Гэр гэдэг нь төв Азийн улсуудын сууц хэлбэрийн мод, эсгийгээр хийсэн уламжлалт сууц; *байшин* гэдэг нь нэг айл суух ихэвчлэн мод, цемент, тоосгоор барьсан барууны маягийн гэрээс бусад хэлбэрийн сууц; *орон сууц* гэдэг нь хоёр болон түүнээс дээш тооны айл өрх амьдран суух байшин бөгөөд ихэвчлэн хэдэн арван айл амьдардаг барилга юм.

Гэр болон байшин сууц нь түүхий нүүрсийг шатаах замаар халаалтаа шийддэг зуух ашигладаг. Монгол улс сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд энэхүү зуухыг сольж илүү шаталттай сайжруулсан зуухыг нэвтрүүлэх олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

МСС-ийн Эрчим хүч, Байгаль орчны төслийн хүрээнд уламжлалт зуухыг сайжруулсан зуухаар солих ажил эрчимтэй хийгдсэн. Энэ ажлын хүрээнд нийт 97,230 зуухыг айл өрхүүдэд тараасан бөгөөд үүнд Өлзий, Хас, Дөл зуухнууд орох бөгөөд эдгээр зуухнуудыг бид нийтэд нь “МСС-ийн сайжруулсан зуух” гэж үзсэн.

⁶ Зуухнаас гарсан утааны ялгаралтын хэмжээ, нам даралтын зуух ба авто тээврийн хэрэгслийг 2.85 дахин өсгөж одоогийн гадаад орчны агаарын хэмжилттэй дүйцүүлэн тооцлоо. Үүнийг бусад хувилбарууд дээр мөн адилаар тооцсон болно.

Монгол Улсын Засгийн Газраас 2013 оноос эхлэн уламжлалт зуухыг 45,000 гаруй МСС-ийн сайжруулсан зуухаар солих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Бусад халаалтын төрлүүдэд хагас коксжсон нүүрсэн зуух, нам даралтын зуух, халаалтын зуух болон цэвэр төвийн халаалт зэрэг орно.

МСС-ийн сайжруулсан зуух нь уламжлалт зуухтай харьцуулахад өдрийн дундаж агаарын бохирдлын ялгаралт нь (PM2.5 гр/өдөр) 67%-аар буурсан үзүүлэлттэй байгаа нь дотоод агаарын бохирдлын хэмжээг 16%-аар бууруулсан дүнтэй байна.

Хагас коксжсон нүүрсээр галладаг ердийн айл өрхийн ашигладаг халаах зуух болон халаалтын зуухууд нь гадаад орчинд утааны ялгаралтыг бий болгодог, харин дотоод орчинд утаа ялгаруулахгүй. Нам даралтын зуух болон төвлөрсөн уурын түгээлт нь эрчим хүч болон халаалтын хосолмол үйлдвэрлэлийн явцад бий болдог.

Бид бага хэмжээний нарийн ширхэглэгт тоосонцорыг (PM2.5) үүсгэж буй бусад халаалтын төрлүүдийг “бусад сайжруулсан халаалтын төрлүүд” нэртэйгээр оруулсан ба энэхүү төрөлд нь эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх төрийн бодлого төлөвлөгөөтэй тохирч байгаа юм. Энэхүү ирээдүйн шинэ технологийн зуух нь утааны ялгаралтыг МСС-ийн сайжруулсан зуухны утааны ялгаралтаас даруй 60%-аар, дотоод орчны агаарын бохирдлын хэмжээг 16%-аар дахин нэмэлтээр бууруулна гэж тооцсон.⁷

Зуух нь зөвхөн гэр ба байшинд зориулагдсан ба нэг өрхөд нэг зуух ашиглагдана гэж тооцсон. Нам даралтын зуух зөвхөн байшинтай айлд тохирох бол халаалтын зуух нь орон сууцанд л байхаар тооцсон. Түүнчлэн уурын халаалт ба бусад сайжруулсан халаалтын төрлүүд нь бүх төрлийн орон сууцанд байхаар тооцоолсон.

Суурь түвшин – д МСС-ийн зуухнуудыг төрийн бодлогын хүрээнд тараасан ба 2013 онд эдгээр МСС-ийн зуухнуудын борлуулалтыг банк зохицуулдаг болсон. Төрийн бодлогын хүрээнд нам даралтын зуух, сайжруулсан халаалт, хагас коксжсон нүүрсэн зуухны аль нэгийг ашигладаггүй гэр хорооллын өрхүүдэд ойрын хугацаанд МСС-ийн сайжруулсан зуухыг 100% суурилуулах зорилго тавьсан. Дээрх үндэслэлээр Баянгол дүүрэг⁸ болон бусад нам даралтын зуух бүхий айл өрхүүдээс бусад нийслэлийн бүх дүүргийн өрхүүдэд МСС-ийн сайжруулсан зуухыг 100% тараасан байна. Цэвэр Агаар Сангийн мэргэжилтнүүдийн мэдээлснээр 2013 оны байдлаар Улаанбаатар хотод 20,000 нам даралтын зуух (нийт байшинтай өрхүүдийн 19% нь) бүхий байшинтай өрхүүд байна. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан баримтаар 2010 оны байдлаар нийт 14,186 нам даралтын зуухтай айл өрх Улаанбаатар хотод байгаа гэсэн нь дээрх мэдээллийг баталж байна. Мөн түүнчлэн нийт орон сууцны 86% нь төвийн халаалтаас дулаанаар хангагддаг болохыг мэдээллэсэн байдаг. Эдгээр тоо баримтууд нь 2014 онд⁹ мөн хэвээр байна гэж үзэн судалгаандаа оруулсан. Холбогдох албаны мэргэжилтнүүдийн мэдээлснээр 2013-2014 онд шилжих өвөл орон сууцанд амьдардаг үлдсэн 14%-д багтах айл өрхүүд нь 189 халаалтын зуухаар дулаанаа хангадаг гэж тодорхойлсон¹⁰.

Төлөв 2013-ын дагуу бүх гэр, нам даралтын зуух хэрэглэдэггүй нийт байшингууд нь МСС-ийн сайжруулсан зуухаар бүрэн солигдоно гэж үзсэн. Энэ хувилбар нь суурь түвшингээс

⁷ Ирээдүйн шинэ дэвшилтэт зуух нь утаа бууруулдаг байна гэж тооцсон.

⁸ Баянгол дүүрэг дэх түүхий нүүрсийг хориглосон хууль нь зөвхөн хагас коксжсон нүүрс хэрэглэж байна. 2012 оны хүн ам зүйн мэдээллээс харахад, энэ дүүргийн гэр сууцтай айлуудын 7% нь, байшин сууцтай айл өрхүүдийн 6% нь л хагас коксжсон нүүрсийг түлж байна.

⁹ Төвийн халаалттай айл өрхүүдийн нийт эзлэх хувийг нь өөрчлөөгүй учир нь айл өрхүүдийн тоо нь байнга ихсэж байх болно, жишээлбэл дунд оврын нам даралтын зуухнаас халаалтаа хангадаг айл өрхүүд төвийн халаалтанд яваандаа холбогдоно. Энэ нь судалгааны суурь шугаманд хувь нь ихсэх тусам утааны ялгаралтын хэмжээг багасна.

¹⁰ ШУТИС-ийн ахлах багш ТУ-ны доктор Баттогтохоос мэдээллийг авсан – 2013 оны намар.

эхлэлтэй. Нийслэлийн хэмжээнд одоо байгаа 20,000 нам даралтын зуух цаашид ч энэ хэмжээнд байна. Халаалтын зуухны технологи нь хуучрах учир 2024 хүртэл хуучрахгүй одоо байгаа 189 нам даралтын зуухны тоо нэмэгдэхгүй. 2014 оны байдлаар төвлөрсөн шугамаас халаалт авахгүй байгаа 14%-ийн орон сууцны өрхүүдийн тоо 25,488 байсан нь 2024 онд өөрчлөгдөхгүй тул нийт орон сууцанд амьдрагсдын 6%-тай тэнцэж буурна. Бусад орон сууцнууд нь сайжруулсан буюу төвийн халаалтын шугамд холбогдоно.

Хувилбар 1-ийн дагуу гэрт амьдардаг өрхүүд 100% ирээдүйн шинэ технологийн зуухаар солигдох, нам даралтын зуух хэвээрээ ба байшинтай айл өрхүүдийн 50% нь ирээдүйн шинэ технологийн зуухаар солигдож, үлдсэн 50% нь сайжруулсан халаалтын системд шилжинэ. Энэ үед халаалтын зуухны цэвэр төвийн халаалттай орон сууцны тоо Төлөв 2013-ын үеийн тооноос өөрчлөгдөхгүй.

Хувилбар 2-ын дагуу гэр болон байшин сууцтай айл өрхүүд 100% цэвэр халаалтын системд шилжих бөгөөд халаалтын зуухууд ашиглалтаас гарч бүх орон сууцны байшингууд төвийн халаалтад холбогдоно. Доорх хүснэгтэд суурь түвшин, Төлөв 2013, болон Хувилбар 1,2-ын түвшинд зуухнуудын тоог төрлөөр нь харуулсан болно (Хүснэгт А1, А2).

Хүснэгт А1. Суурь түвшин (2014) болон төлөвлөсөн хувилбаруудын үеийн айл өрхүүдийн халаалтын зуухны төрөл

	Гэр (хувиар)	Гэр (тоо)	Байшин (хувиар)	Байшин (тоо)	Орон сууц (хувиар)	Орон сууц (тоо)
<i>2014 он – Суурь түвшин</i>						
МСС-ийн сайжруулсан зуух	93	80,122	75	79,972	0	0
Хагас коксжсон нүүрсэн зуух	7	6,123	6	6,381	0	0
Нам даралтын зуух	0	0	19	20,000	0	0
Халаалтын зуух	0	0	0	0	14	25,488
Цэвэр: төвийн халаалт, хий, цахилгаан	0	0	0	0	86	154,230
<i>2024 он – Төлөв 2013</i>						
МСС-ийн сайжруулсан зуух	100	94,834	83	96,943	0	0
Нам даралтын зуух	0	0	17	20,000	0	0
Халаалтын зуух	0	0	0	0	6	25,488
Цэвэр: төвийн халаалт, хий, цахилгаан	0	0	0	0	94	389,707
<i>2024 он – Хувилбар 1</i>						
Ирээдүйн шинэ технологи бүхий зуух	100	94,834	41	48,472	0	0
Нам даралтын зуух	0	0	17	20,000	0	0
Халаалтын зуух	0	0	0	0	3	12,744
Цэвэр: төвийн халаалт, хий, цахилгаан	0	0	41	48,472	97	402,451
<i>2024 он – Хувилбар 2</i>						
Цэвэр: төвийн халаалт, хий, цахилгаан	100	94,834	100	116,943	100	415,195

Удахгүй хэвлэгдэж гарах Сошиал Импакт компанийн нөлөөллийн үнэлгээний үр дүнгийн эцсийн тайланд орсон МСС-ийн сайжруулсан зуухны (Өлзий, Хас, Дөл) утааны ялгаралтын мэдээллийг бид өөрсдийн судалгаанд ашигласан.

Нийслэлийн нам даралтын зуух, хагас коксжсон нүүрсэн зуухны бохирдуулагчийн өгөгдөлийн талаар мэдээлэл хангалтгүй байсан тул МСС-ийн сайжруулсан зуухны утааны ялгаралтын өгөгдлөөр дүйцүүлэн тооцлоо. Ирээдүйн шинэ технологийн зуухны утааны ялгаралтыг үнэлэхдээ МСС-ийн сайжруулсан зуухыг Сошиал Импакт компанийн үнэлгээ хийсэн байдлаар буюу уламжлалт зуухнаас МСС-ийн сайжруулсан зуух руу шилжсэнтэй төстэй байхаар тооцсон.

Халаалтын зуухны утааны ялгаралтын үнэлгээг 2013 онд ЖАЙКА (ЖАЙКА, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг – JICA, Japan International Cooperation Agency) байгууллагын боловсруулсан утааны ялгаралт тоосонцорын илтгэлээс том ширхэглэгт тоосонцорын (PM10) мэдээллийг ашигласан. Хотын бүх яндангаас гарсан утааны ялгаралтын тоосонцорын хэмжээг нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээтэй адилаар авч үзсэн ба 2014 оны байдлаас Төлөв 2013-ын хувьд өөрчлөлтгүй, 2024 оны Хувилбар 1-т утааны ялгаралтын тоосонцорын хэмжээг нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5) байхаар үнэлсэн. Хувилбар 1-т халаалтын зуухнуудын утааны ялгаралт 70%-аар буурахаар тооцсон нь өндөр үр ашигтай циклоноор утааны ялгаралтыг хянах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой юм (ЖАЙКА, 2013). Хувилбар 2-т бүх халаалтын зуухнуудыг ашиглалтаас гаргана гэж тооцсон. Нийт утааны ялгаралтыг Хүснэгт А3-т нэгтгэж харуулав.

Хүснэгт А2. Айл өрхүүдийн тоо

	2014 он	2024 он
Нийт айл өрх	372,317	626,972
Гэр	86,246	94,834
Байшин	106,353	116,943
Орон сууц	179,718	415,195

Хүснэгт А3. Нам даралтын зуухны утааны ялгаралт, хувилбар тус бүрээр

Хувилбар	НДЗ-ны утааны ялгаралт (PM2.5 тн/жил)
2014 он – Суурь түвшин	1,300
2024 он – Төлөв 2013	1,300
2024 он – Хувилбар 1	390
2024 он – Хувилбар 2	0

Цахилгаан станцын утааны ялгаралтын хувилбарууд

Суурь түвшин – 2013 онд ЖАЙКА байгууллагын боловсруулсан дулаан, цахилгаан боловсруулдаг дөрвөн цахилгаан станцуудын (ДЦС-2, ДЦС-3 (2 хэсэг) ба ДЦС-4) тус бүрийнх нь утааны ялгаралт – 2010 оны бүдүүн ширхэглэгт тоосонцорын (PM10) илтгэлийн дагуу бүх яндангаас гарсан утааны ялгаралтын тоосонцорын хэмжээг нарийн ширхэглэгт тоосонцороос (PM2.5) бага гэж үзэн 2014 онд өөрчлөлтгүйгээр тооцсон. 2024 оны Төлөв 2013-т ДЦС-5-ыг ашиглалтанд нэмж орсон байхаар тооцсон.

2013 оны зун Монголын засгийн газар болон GDF Suez SA групптэй цахилгаан станц барих санамж бичигт гарын үсэг зурсан байдаг. Одоогийн төлөвлөснөөр 450 MW хүчин чадалтай ба цаашид 820 MW хүчин чадалтай болгож өсгөхөөр тооцсон (Нийслэл цэвэр агаар төсөл, 2012) учир бид 2024 оны хувилбартаа өргөтгөсөн чадлаар нь оруулж тооцсон. Хэрэв төлөвлөгөө ёсоор хэрэгжвэл 2017 он гэхэд үйл ажиллагаагаа бүрэн чадлаар нь явуулж эхлэх ба нийслэлийн төвөөс хойд зүгт 15 км зайтай оршино. Энэ шинэ станцын утааны ялгаралтын хувь нь станцын үр ашигтай ажиллагаа ба нүүрсний чанараас шууд хамаарна. Цахилгаан станцын одоогийн ерөнхий загвараар дундаж цахилгаан үйлдвэрлэлт нь цагт 1870 kW*цаг/тн нүүрсийг хэрэглэх ба дулаан үйлдвэрлэлт нь цагт 19.53 MMBtu/тн нүүрсийг ашиглахаар тооцжээ.

Энэ цахилгаан станц нь АНУ-ын шинээр баталсан стандарт New Source Performance Standard (NSPS) түвшинтэй (цахилгааны хүчин чадал нь 0.015 lbPM/MMBtu) тохирч байхаар тооцжээ. ДЦС-5 нь жилийн турш ажиллан ойролцоогоор 511 тн/жил нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5) утааны ялгаралтыг гаргана.

Хувилбар 1-т түрүүчийн хувилбарууд давтагдаж ДЦС-2,3,4-ийн утааны ялгаралт дээр нь өндөр үр ашигтай цахилгаан соронзон шүүлтүүр (electrostatic precipitators – ESP) тавина. Тоосонцоруудын шүүлтийн хувь нь 98% гэж тооцож байгаа ба цахилгаан соронзон шүүлтүүрийг зөв суулгаж, ашиглаж чадвал шүүлтийн нь 99% хүртэл ашигтай ажиллах боломжтой юм. Эдгээрийг хэрэгжүүлснээр нийслэлийн ДЦС-ын байгууламжид томоохон өөрчлөлтүүд хийгдэж, нойтон шүүгч (wet scrubbers) эсвэл цахилгаан соронзон шүүлтүүрийн аль нэгийг нь тухайн станцын байгууламжаас нь шалтгаалж сонгон байрлуулна. 98% хүртэл шүүх гэдэг нь утааны ялгаралтын фактор хяналтгүйгээр 16.6 кг тоосонцор/тн нүүрс гаргахтай тэнцэнэ.

Хувилбар 2-т дээр дурьдсан бүх хувилбарууд давтагдана. ДЦС-2-ыг хаагдахаар тооцно. Нийт утааны ялгаралтыг Хүснэгт А4-т нэгтгэж харуулав.

Хүснэгт А4. Хувилбар тус бүрийн ДЦС-ын утааны ялгарал

Хувилбар	ДЦС-ын утааны ялгаралт (PM2.5 тн/жил)
2014 он – Суурь түвшин	11,500
2024 он – Төлөв 2013	12,000
2024 он – Хувилбар 1	1,900
2024 он – Хувилбар 2	1,830

Авто тээврийн хэрэгслийн утааны ялгаралтын хувилбарууд

Авто тээврийн хэрэгслийн утааны ялгаралтын байдлыг тодорхойлохдоо тухайн авто тээврийн хэрэгслийн хэдэн жил явсан хэмжээнээс нь нэгж км явахад ялгарах утааны ялгаралтыг тооцож гаргадаг. Ингэхдээ тээврийн хэрэгслийн нас, утааны ялгаралт, засвар үйлчилгээ хийлгэсэн байдал болон замын бөглөрөл зэргээр нь ангилж тооцох шаардлагатай. Энэхүү судалгааны ажлын хүрээнд энгийн мэдээлэл-өгөгдөл ашиглахаас гадна автомашины утааны ялгаралтын талаар дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах нь судалгааны багийн бас нэг чухал ажил байсан юм. 2010 онд ЖАЙКА байгууллага төв болон туслах зам дээр явсан машинуудын утааны ялгаралтаас гарах том ширхэглэгт тоосонцорын (PM10) мэдээллийн санг бүрдүүлсэн байдаг (2013 он).

Бид бүх төрлийн авто тээврийн хэрэгслээс ялгарч буй утааны ялгаралтын нийт тоосонцорыг нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5) гэж үзсэн. Энэ тоосонцорын ялгаралтын мэдээнд тормос, дугуй болон замын тоосыг оруулаагүй болно. 2014 оны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ялгаралт 2010 оныхтой харьцуулахад 1.7 дахин ихэссэн нь хотын хэмжээнд явж буй бүртгүүлсэн машины тоо ихэссэнтэй холбоотой юм. Үүнийг тооцохдоо 2010-2013 оны хооронд машины тоо бараг 2 дахин нэмэгдсэн болон гарагаар дугаарын хязгаарлалт хийх болсонтой холбоотой юм.

2024 оны Төлөв 2013-т машины утааны ялгаралт 2014 оныхтой харьцуулахад 1.3 дахин ихэссэн байна. Энэ хэмжилтийг дараагийн 10 жилийн хугацаанд утааны ялгаралт жилд 2.5%-аар өссөн тооцоон дээр үндэслэж гаргасан. Машины тоо жил ирэх тусам өсч байгаа тоотой харьцуулахад энэ өсөлт харьцангуй бага санагдах боловч орчин үеийн машины байгууламж (утаагүй машин гэх мэт) өөрчлөгдөж байгаатай холбон тайлбарлаж болно.

Төлөв 2013-т утааны ялгаралтын тооцоо нь Евро III стандартын дагуу бодогдсон бол Хувилбар 1-т Евро V утааны ялгаралтын стандарттай илүү дөхөж очно. Дизелээр явдаг машины хувьд Евро V утааны ялгаралтын стандарт нь Евро III-тай харьцуулахад 80-93% бага байна. Бензинээр ажилладаг машинуудын тоосонцорын ялгаралтанд зориулсан Евро стандарт байдаггүй тул ерөнхийдөө 90%-ийн бууралттай гэж тооцож болох юм. Бензинээр ажилладаг машинуудын нүүрсустөрөгчийн (ТНС) стандартууд Евро V-ынх Евро III-тай харьцуулахад 50%-аар бага байдаг. Түүнчлэн өвлийн хүйтэн улиралтай газарт тоосонцорын бохирдол буурч байгаа нь дэгдэмхий хийнүүд тоосонцортой холилдсон байдагтай холбоотой. Энэхүү арга хэмжээнүүдийн үр дүнд эдгээр үзүүлэлтүүд нь 2014 оныхтой харьцуулахад 75%-ийн бууралттай байна.

Хувилбар 2-т дээрх бүх үзүүлэлтүүдийг хэвээр авч Хувилбар 1-ийг 50% нэгжээр бууруулж тооцно. Их хэмжээний бууралтыг тогтвортой барихын тулд олон тооны машин хот дотор явах асуудал дээр хяналт тавих, замын хөдөлгөөний урсгалыг зөв зохицуулах, замын хөдөлгөөний нэгдсэн сүлжээ удирдлагатай болох, Евро VI утааны ялгаралтын стандартыг нэвтрүүлэх зэрэг орно. Мөн Евро VI утааны ялгаралтын стандарт нь Евро V-тай харьцуулахад дизелээр явдаг том оврын тээврийн хэрэгслийн тоосонцорын ялгаралт 50% буурна. Нийт утааны ялгаралтыг Хүснэгт А5-т нэгтгэж харуулав.

Хүснэгт А5. Хувилбар тус бүрийн автотээврийн хэрэгслийн утааны ялгаралт

Хувилбар	Автотээврийн хэрэгслийн утааны ялгаралт (тн РМ2.5/жил)
2014 он – Суурь түвшин	384
2024 он – Төлөв 2013	500
2024 он – Хувилбар 1	96
2024 он – Хувилбар 2	48

Үр дүнгийн таамаглал ба тэдгээрийн эх үүсвэр

2014 он – Суурь түвшин¹¹

- Зуухнууд – 100% МСС-ийн сайжруулсан зуухны¹² утааны ялгаралтын мэдээллийг Сошиал Импакт¹³ компаний судалгаанд үндэслэнэ.
- Халаалтын зуух – утааны ялгаралтын мэдээллийг ЖАЙКА 2010 том ширхэглэгт тоосонцорын (PM10) хэмжилтийн мэдээлэл (PM2.5-р тооцсон)
- Тээврийн хэрэгсэл – ЖАЙКА 2010 том ширхэглэгт тоосонцорын (PM10) утааны ялгарал нь 1.7 дахин ихэссэн (PM2.5-р авснаар тооцсон),
- Цахилгаан станц – утааны ялгаралтын мэдээллийг ЖАЙКА 2010 том ширхэглэгт тоосонцорын (PM10) хэмжилтийн мэдээлэл (PM2.5-аар тооцсон)

2024 он – Төлөв 2013

- Зуухнууд – технологийн өөрчлөлт гарахгүй (зуухны тоо цөөн тоогоор нэмэгдсэн)
- Халаалтын зуух – өөрчлөлтгүй
- Тээврийн хэрэгслүүд – суурь түвшингийн 130%
- Цахилгаан станц – одоогийн нөхцөл өөрчлөгдөхгүй ба ДЦС-5 шинээр ашиглалтанд орсон байхаар илүү үүссэн эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

2024 он – Хувилбар 1

- Зуухнууд – Нам даралтын 20,000 зуухыг МСС-ийн сайжруулсан зуухтай дүйцүүлэн тооцно. Ирээдүйн шинэ технологийн зуухны утааны ялгаралт МСС-ийн сайжруулсан зуухны 40%, бусад зуухнуудаас гарах утаа 60% багасна.
- Халаалтын зуух – өндөр үр ашигтай циклоныг суурилуулснаар утааны ялгаралт 70%-аар буурна
- Тээврийн хэрэгсэл – Евро V стандартыг авч хэрэгжүүлснээр суурь түвшингийн 25% болно
- Цахилгаан станц – ДЦС 2, 3, 4-д 98%-ийн үр ашигтай цахилгаан соронзон шүүлтүүрийг суурилуулна

2024 он – Хувилбар 2

- Зуухнууд – утаагүй зуух (бүх зуухыг хийн, шингэн эсвэл цахилгаан болгоно).
- Халаалтын зуух – ашиглагдахгүй
- Тээврийн хэрэгсэл – Евро VI стандартыг нэвтрүүлснээр машины утаа суурь түвшингийн 12.5% болно
- Цахилгаан Станц – Хувилбар 1-ийн үр дүн дээр нэмэлтээр ДЦС-2-ыг ашиглахаа болино

¹¹ Зуух, халаалтын зуух, тээврийн хэрэгслээс үүссэн утааны найрлагын ойролцоогоор 2.85 коэффициентээр ихсэж байгаа нь одоогийн тоосонцорын хэмжээтэй тохирч байна гэж тооцоолсон. Энэ хэмжээг бүх хувилбарт адилаар тооцсон. Энэ нь ТҮЦ-ийн зуух, жижиг дулааны дэд станц, үйлдвэрлэлийн утааны ялгарал, замын болон салхины тоос шороог оруулаагүй тооцоо болно. Зуны улиралд шорооны тооцоог нэмэлтээр оруулж бодох шаардлагатай.

ХАВСРАЛТ Б.

ГАДААД ОРЧНЫ АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖЭЭ

Гадаад орчны агаарын чанарын загварчлал

Гадаад орчны агаарын чанарын загварчлал нь агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жингийн агууламжийг тогтоох зорилготой юм. Энэ загварчлалын арга нь МСС-ийн Энерги хүч, Байгаль орчны төслийн гүйцэтгэгч Сошиал Импакт компанийн нөлөөллийн үнэлгээнд ашигласантай төстэй юм. Энэ судалгаа нь утааны ялгаралтын хувилбарууд болон бусад утааны ялгаралтын эх үүсвэрүүдийг нэмж оруулсан томоохон хэмжээний судалгаа болсон. Энэ загварчлалын нарийвчилсан тайлбарыг Сошиал импакт компанийн нөлөөллийн үнэлгээний эцсийн тайланд оруулсан тул энэхүү судалгааны тайланд зөвхөн товч тайлбарыг орууллаа.

Гадаад орчны газрын түвшин дэх нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээг тооцохдоо дараах загварчлалыг ашигласан. Үүнд: түр хугацааны үйлдвэрлэлийн эх үүсгэврүүдийн иж бүрдэл, загвар 3 (Industrial Source Complex Short-Term, version 3 – ISCST3), дисперс загварчлал, АНУ-ын Байгаль Орчныг Хамгаалах Агентлаг, 1955 он (United States Environmental Protection Agency – US EPA, 1995).

Загварчлалыг гаргахдаа 2012 оны 6 дугаар сараас 2013 оны 5 дугаар сар хүртэл хугацааны нэг цагийн алхамтай буюу цаг тутамд орчны хэм, салхины хурд ба чиглэлийг агаарын чанарын хэмжилтийн станц-4 (UB04)-ын хэмжилтийн өгөгдлөөс авсан. Энэ станц нь Цаг Уур Орчны Шинжилгээний Газрын (ЦУОШГ) харъяа хэмжилтийн цэг юм. Мөн түүнчлэн нарны цацраг, агаарын үе давхаргын холилдсон хэмжилтийг NOAA HYSPLIT-н (National Oceanic and Atmospheric Administration - Hybrid single particle Lagrangian integrated trajectory model) загвар ашиглан гүйцэтгэлээ (Draxler & Hess, 1997, 1998; Draxler, 1999). Өртөлтийн дундаж агууламжийг өдрийн (өглөөний 8 цагаас оройны 16 цаг хүртэл) болон шөнийн (оройны 18 цагаас өглөөний 8 цаг хүртэл); өвлийн (10 дугаар сараас 3 дугаар сар хүртэл) болон зуны (4 дүгээр сараас 9 дүгээр сар хүртэл) улирлаар тус тус хэмжсэн.

Айл өрхийн галлагааны утааны ялгаралт, нам даралтын зуух, тээврийн хэрэгсэл, ДЦС-ын утааны ялгаралтыг бид загвартаа оруулж тооцсон. Бусад төрлийн галлагааны үүсгэврүүдийг оруулаагүй. Үүнд: зуухаар галладаг жижиг ТҮЦ, үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч буй утааны ялгаралт, замын тоос, салхинаас уруудаж ирсэн тоос зэрэг багтана.

ДЦС-ууд цэгэн (point) эх үүсгэврүүдээр, харин гэр болон байшингийн янданг хавтгай (area) газарзүйн байршилаар загварчилсан. Ингэхдээ Улаанбаатар хотын нийт нутаг дэвсгэрийг 1км×1км харьцаатай нийт 6,298 шоо дөрвөлжинд хуваасан. Утааны ялгаралтыг масштаб торонд байрлуулж, масштаб тус бүр нь ялгарал хүлээн авагч, эндээс нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) загварыг гаргаж авсан.

Багануур, Багахангай дүүргүүдийг энэ загварчлалд оруулаагүй. Сошиал Импакт компанийн нөлөөллийн үнэлгээний эцсийн тайланд айл өрхүүдийн зуухны утааны ялгаралт, эдгээрийн байрлал ба цаг хугацааны нарийвчилсан тайлбарыг оруулсан. Нийт 200 айл өрхийн утааны ялгаралтын хэмжилт болон зуухны яндангийн тоосонцорыг хэмжсэн үзүүлэлтийг бид загвартаа ашигласан. Эдгээр өгөгдлүүд нь уламжлалт зуух, МСС-ийн хөтөлбөрийн хүрээнд тараагдсан сайжруулсан зуухнуудын ялгаралтын хүчин зүйлс болон гэр, байшин сууцны хүчин зүйлс зэргийг утааны ялгаралтыг тодорхойлоход ашиглагдсан (PM2.5 гр/кг нүүрс нэгжээр).

Нүүрсний өдрийн дундаж хэрэглээний хувийг тодорхойлохдоо Сошиал Импакт компанийн нөлөөллийн үнэлгээ хийсэн 1,096 айл өрхөөс авсан асуулгыг ашигласан. Энэ асуулга судалгаа нь халаалтын улирлын үеийг намрын адаг сар, өвөл, хаврын эхэн сар гэсэн гурван бүлэгт хувааж судалгааг явуулсан.

Уг судалгааны асуулгыг зуухны төрөл болон сууцны байдлаар нь ангилан утааны ялгаралтын хэмжээг цаг тутамд тооцсон. Энэ нь зуухны галлагааны горим, галаа түлэх үеийн утааны ялгаралтыг хэмжих зэрэг үзүүлэлтүүдээр тодорхойлсон.

МСС-ийн сайжруулсан зуухны тараалтын судалгааг Хаан Банк, Хас Банкны мэдээллээс ашигласан. Эдгээр мэдээлэлд дүүрэг, хороогоор тараасан зуухнуудын тоо, төрөл зэрэг мэдээлэл багтсан байдаг. МСС-ийн сайжруулсан зуухны тараалтыг хороо тус бүрээр нь ангилан 1км×1км масштабээр оруулж тооцсон газарзүйн мэдээллийн систем (GIS) ашигласан.

Гэр хорооллын хороодын зах хязгаарыг зөвхөн хүн ам суурьшсан хороодыг газарзүйн зурагт оруулсан. Нийт гэр хорооллын зуухтай айл өрхүүдийг хороо тус бүрээр нь гаргаж 2012 оны айл өрхийн тооллогод оруулж, нэг өрхөд нэг зуух хэрэглэхээр тооцсон (Үндэсний статистикийн газар, 2012). 2013 оны ЖАЙКА-ийн мэдээллэснээр хороодын гэр хорооллын зуухны тоо 20%-аар өссөн тоо гарсан байна. Газарзүйн байршлаар нь харуулсан утааны ялгаралтын зураглалд (масштабаар харуулсан газарзүйн байршил) зөвхөн МСС-ийн төлөвлөж зарсан зуухны утааны ялгаралтыг оруулсан. Нэг масштабд МСС-ийн 5 болон түүнээс бага тоотой зуухнууд орсон.

Нийслэл дэх нам даралтын зуухны утааны ялгаралтын өгөгдлийг олох боломжгүй байсан тул МСС-ийн сайжруулсан зуухны утааны ялгаралаар дүйцүүлэн тооцлоо. Ирээдүйн шинэ технологийн зуухны утааны ялгаралтыг МСС-ийн сайжруулсан зуухны утааны ялгаралтын бууруулсан түвшинтэй (Сошиал Импакт компанийн тооцсон утааны ялгаралтын бууруулалт) адил хэмжээгээр буурсан байх хувиар бодож оруулсан. 2012 онд гэрт амьдардаг өрхийн зуухны тоо нь газарзүйн зургийн масштаб дээр 2012, 2014 ба 2024 онуудын хувилбар дээр өөрчлөгдөж гарна. Бусад байшинд амьдардаг өрхүүдэд мөн адил байдлаар хийгдсэн. Нам даралтын зуух болон ирээдүйн шинэ технологийн зуухыг мөн адил газарзүйн зурагны масштаб тус бүрт жигд тархаан тооцсон. Гэр хорооллын айл өрхүүдээс зуны улиралд зуухны утааны ялгаралт байхгүй гэж тооцсон.

Гуттикунда нарын 2010 оны утааны ялгаралтын төрлийн $0.01^{\circ} \times 0.01^{\circ}$ харьцаатайгаар газарзүйн байршилаар оруулсан (Гуттикунда нар, 2013). Тиймээс эдгээр газарзүйн зургийг дахиж төлөвлөн 1км×1км болгон өөрчилж үнэлгээг шинэчлэн гаргав. Нам даралтын зуух болон авто тээврийн хэрэгслийн утааны ялгаралтыг Гуттикунда нарын хэмжилтээс авч мөн зохих өөрчлөлтүүдийг оруулан зуны улиралд зуухны утааны ялгаралт байхгүй гэж тооцсон. Авто тээврийн хэрэгслийн утааны ялгаралтыг бүх улиралд адилхан гэж үзэж хоногийн агууламжийн тооцохдоо (өглөө болон орой) ачааллын үеийг цагаар үнэлсэн. 2012 онд хорооны төвшинд хүн амыг амьдрах сууцны төрлөөр нь (гэр, байшин, орон сууц) 1км×1км масштабт багтаан газарзүйн зурагт оруулсан. 2012 онд гэрт амьдардаг өрхийн иргэдийн 2012, 2014 болон 2024 онуудын хувилбарууд дээр оноо дагаад өөрчлөгдөнө. Байшинд амьдардаг өрхийн тоо оноо дагаад хувилбар тус бүр дээр өөрчлөгдөнө. Орон сууцанд амьдардаг өрхийн тоо мөн төлөвлөсний дагуу масштаб тус бүр дээр өөрчлөгдөнө.

Ийнхүү хувилбар тус бүрийн загварчлалыг хяналтын үзүүлэлтүүдтэй харьцуулан үнэллээ. Хяналтын дэлгэрэнгүй мэдээлэл хангалтгүй байдаг. Жишээлбэл 2012-2013 оны хооронд

халаалтын улирлын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жингийн агууламжийн мэдээг зөвхөн нэг газраас (агаарын чанарын хэмжилтийн станц-2 – UB02) цуглуулсан байдаг. Энэ станц нь төв замын дуагуу байрлалтай тул замын хөдөлгөөний тоос шороо нь их байсан учраас загварчлалаар үүнийг хооронд нь ялган үнэлэх боломжгүй байлаа. Түүнчлэн гадаад орчны агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) мэдээллийг Екограф (Ecography) болон Ековорлд (Ecoworld) компаниас авч харьцуулсан. Эдгээр компаниуд нь МСС-тай байгуулсан гэрээний үндсэн дээр мэдээллүүдийг нь цуглуулсан. Дээж авсан газар, аргачлал, үндсэн үр дүнгийн үзүүлэлт зэрэг нь Сошиал Импакт компанийн нөлөөллийн үнэлгээний эцсийн тайланд орсон. Эдгээр хэмжилтүүдийг 2013 оны 1 дүгээр сарын 22-ноос 4 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд гэр хорооллын айл өрхүүдийн дунд байрлуулсан дөрвөн хэмжилтийн цэгээс авсан.

Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дээжийг 24 цагийн турш шүүгч шүүлтүүрт (өдрийн 12 цагаас дараа өдрийн 12 цаг хүртэл) хоёроос гурван өдрөөр цуглуулж, нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жингийн болон химийн найрлагыг шинжилсэн. 2013 оны 1 нэгдүгээр сарын 22-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийн хэмжилтээр цуглуулсан өгөгдлүүдийг 19 дээж ашиглан загварчилсан. 2014 онд төлөвлөсөн ялгаралтын жагсаалтыг МСС-ийн сайжруулсан зуухны хороо тус бүрээр тараасан байдлаар нь тооцсон ба гэр хорооллын айл өрхүүдийн уламжлалт зуухыг МСС-аас авсан мэдээллийн дагуу тооцож оруулсан. Хэмжилтийн цэг тус бүр дээрх нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дундаж хэмжээнүүдийг Зураг Б1-ийн нэгдүгээр баганад (хар) харуулсан. Хүснэгтээс хэмжилтийн цэгүүдийн үзүүлэлтүүд хоорондоо зөрүүтэй байгаа нь харагдах ба эдгээрийн зөрөө нь 50% орчим байна.


Дээжийг авах цаг хоорондын зайг дундаж агууламжийн хэмжээтэй нь загварчилсан. Түүнчлэн 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэлх бүх өдрүүдийг харуулсан Зураг Б1-ийн хоёрдугаар баганад (саарал) харуулсан. Загварчлалд орсон агууламж нь хэмжсэн бодит тоон утгаас бага зөрүүтэй ба станцууд хоорондын зөрүү бага байна. Ийнхүү хоорондоо зөрүү багатай байгаа нь дараах шалтгаантай байж болно. Үүнд: эдгээр станцууд нь хэмжилтийн алдаа гаргах боломжтой, загварчлал бүх шаардлагатай мэдээллийг бүгдийг нь оруулж чадаагүй, нэг цагаас нөгөө цагийн хооронд хэмжилт хуримтлагдсан байх магадлалтай зэрэг.

Гэр хорооллын зуух, нам даралтын зуух, автотээврийн хэрэгслийн утааны ялгаралтын хэмжилт нь 2.85 коэффициентоор ихэссэнийг загварчлалдаа оруулж тооцсон ба энэ нь дөрвөн хэмжилтээс загварчлалд шилжих харьцаа юм.

Зураг Б1-ийн гуравдугаар баганад (цагаан) масштабт оруулсны дараах нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламжийн загварчлалыг харууллаа. Энэ судалгааны утааны ялгаралтын мэдээллийн цуглуулгын алдаа нь 2010 оны ЖАЙКА-ийн утааны ялгаралтын цуглуулалтаас гурав дахин их, 2010 оны Гуттинда нарын судалгаанаас мөн доогуур гарсан. Утааны ялгаралтын тооллого масштабыг ихэсгэх явцад эдгээр эх үүсгэврүүд ойролцоогоор гурван нэгжээр өсч байсан. Эдгээр газрууд нь 2010 оны ЖАЙКА-ийн хийсэн хэмжилт, Гуттикунда болон бусад эрдэмтэдийн хэмжилт хийж байсан газруудтай ижил юм. Энэ судалгааны хүрээнд ашиглаж буй эдгээр ялгаралтын хэмжилтүүд бодитой гэж үзэх шалтгаан нь хамгийн сайн тооллого-хэмжилт хийсэн хэсэг цэгүүдээс авснаар тайлбарлагдана.

Цахилгаан станцын утааны ялгаралтыг газарзүйн зурагтаа оруулаагүй учир нь ЖАЙКА, Гуттикунда нарын судалгаатай холбоотой юм. Гэр хорооллын айл өрхүүдийн зуух, нам

даралтын зуух болон тээврийн хэрэгслийн утааны ялгарлыг газарзүйн зурагтаа оруулж хувилбарууд дээр загварыг нь гаргасан.



Зураг Б1. 2013 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 3 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл хугацаанд дөрвөн цэгээс хэмжсэн өгөгдөл.

Гадаад орчны агаарын чанарын загварын үр дүнгүүд

Зураг Б2-т хувилбар тус бүрийн хүйтний улирлын (10 сараас 3 сар хүртэл) гадаад орчны агаарын бохирдлын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламжийг харууллаа. Хувилбар 2-ын хувьд хамгийн их дундаж агууламж нь бидний загвараар $\sim 3 \text{ мкг/м}^3$ байсан учир түүний 2024 оны үр дүнг оруулсангүй.

Зураг Б2-т харуулсан гурван хувилбарын загварт Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн их утааны ялгаралтын агууламжтай хэсэг нь гэр хорооллын (энгийн галлагаатай зуух болон нам даралтын зуухыг хэрэглэдэг) хэсэг ихэвчлэн оршдог. Уг загвар нь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламжийн их бага хэмжээг гэр хорооллын хэсгээр харуулсан юм. Өргөн цар хүрээг хамруулан хийсэн энэ судалгаа нь гадаад орчны агаарын бохирдлын агууламж болон хувилбаруудыг харьцуулж тухайн орчин дахь хүн амын өртөлтийг нь харуулсан. Хүснэгт Б1-д нийт хүн амын тархалтаар нь харьцуулж өвөл ба зуны улиралын дундаж, гадаад орчны агаарын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламжийг харуулсан.


Хүснэгт Б1. Хувилбар тус бүрийн өвөл болон зуны улирлын гадаад орчны агаарын бохирдлын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жилийн дундаж хэмжээ

Хувилбар ¹⁴	Зуны улирал Нийт хүн ам	Өвлийн улирал Нийт хүн ам	Гэр хүн ам	Байшин хүн ам	Орон сууц хүн ам
2014 – Суурь түвшин	6	138	137	144	133
2024 – Төлөв 2013	19	163	162	169	161
2024 – Хувилбар 1	12	69	70	72	68
2024 – Хувилбар 2	10	12	12	12	12


Хувилбар 1-ийн өвөл ба зуны улиралд 2024 онд хүн амд ногдох дундаж агууламж 60%-аар буурна. 2024 онд 69 мкг/м³ байгаа хэдий ч энэ дундаж хэмжээ нь их хэвээр байна. Зураг Б3-т өвлийн улирлын гадаад орчны агаарын бохирдлын хэмжээг хүн амд жинлэсэн байдлаар харууллаа. Хувилбар тус бүр дээр хүн амын 10%-ийн тархалттай хэсгийн гадаад орчны агаарын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламж ~50% байгаа нь Хүснэгт Б1-ийн дундаж үзүүлэлтээс их байна.

Өвлийн улирал
PM2.5
UB4 салхи


Хэмжээ, мкг/м³



2014 Суурь түвшин



2024 Төлөв 2013




2024 Хувилбар 1



Зураг Б2. Хувилбар тус бүрийн өвлийн улирлын гадаад орчны агаарын бохирдлын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламж

¹⁴ 2024 оны Төлөв 2013-ын зуны улирлын нийт хүн ам, өвлийн улирлын нийт хүн ам, өвлийн улирлын гэр сууцанд амьдардаг хүн ам, өвлийн улирлын байшинд амьдардаг хүн ам болон өвлийн улирлын орон сууцанд амьдардаг хүн амын загварт оруулсан тоон утга нь 9, 153, 152, 159, 151 мкг/м³ байв. 2024 оны Хувилбар 1-ийн зуны улирлын нийт хүн ам, өвлийн улирлын нийт хүн ам, өвлийн улирлын гэр сууцанд амьдардаг хүн ам, өвлийн улирлын байшинд амьдардаг хүн ам болон өвлийн улирлын орон сууцанд амьдардаг хүн амын загварт оруулсан тоон утга нь <2, 59, 60, 62, 58 мкг/м³ байв. 2024 оны Хувилбар 2-ын зуны улирлын нийт хүн ам, өвлийн улирлын нийт хүн ам, өвлийн улирлын гэрт амьдардаг хүн ам, өвлийн улирлын байшинд амьдардаг хүн ам болон өвлийн улирлын орон сууцанд амьдардаг хүн амын загварт оруулсан тоон утга нь <1, <2, <2, <2 мкг/м³ байв. Эдгээр тоон утгуудыг ашиглахдаа 10 мкг/м³ хүртэлхийг тооцож бусад агаарын бохирдлын эх үүсвэрүүдийг оруулаагүй болно. Ингэснээр замын тоос, үйлдвэрлэлээс эх үүсвэртэй агаар бохирдуулагч, салхинаас үүссэн тоос зэргийг нийтэд нь хамруулан тооцсонтой адил юм.



Зураг Б3. Өвлийн улиралд хүн амд ногдох гадаад орчны агаарын бохирдлын нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээ

ХАВСРАЛТ В.

ДОТООД ОРЧНЫ АГААРЫН БОХИРДЛЫН ХЭМЖЭЭ

Дотоод орчны агаарын бохирдолд 2.5 микроноос (мкм) бага голчтой нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээ сууцны төрөл, халаалтын эх үүсвэр, тамхины утаатай орчин болон улирлаас нь хамааруулан тооцооллоо. Энэхүү судалгаанд Улаанбаатар хотод бүртгэгдсэн бүх төрлийн сууцны ангиллыг багтаасан. Тухайлбал гэр, байшин болон орон сууц гэсэн төрлүүдийг хамруулсан. Сууцны төрлийн нарийвчилсан тайлбарыг Хавсралт А-д оруулсан.

Дулааны эх үүсвэр, тамхидалт ба дотоод орчны агаарын бохирдлын загварчлал

Албаны мэргэжилтнүүд болон агаарын чанарын талаар мэргэшсэн судлаачдын тодорхойлсноор нийслэлийн халаалтын үндсэн эх үүсгэврүүд нь нүүрсэн галлагаатай уламжлалт зуух, дээрээсээ галлаж эхэлдэг зуух (Өлзий, Хас, Дөл), хагас коксжсон нүүрсэн зуух, нам даралтын зуух халаалтын зуух болон төвийн халаалтын систем зэрэг болно. МСС-ийн Эрчим хүч, Байгаль орчин төслийн хүрээнд дээрээсээ галлаж эхэлдэг зуухыг уламжлалт зуухтай харьцуулахад утааны ялгаралт нь харьцангуй бага байсан тул “МСС-ийн сайжруулсан зуух” гэж нэрлэн тооцоондоо орууллаа.

Судалгааны баг бусад сайжруулсан халаалтын хэрэгслийг (хийн, цахилгаан болон бусад) тусад нь нэг төрөл болгон оруулж, засгийн газрын эрчим хүч, дулааны эх үүсгэврийг хөгжүүлэх төлөвлөгөөнд оруулах боломжтой хувилбарыг боловсруулж үүнийгээ “ирээдүйн шинэ технологийн зуух” гэж нэрлэн МСС-ийн сайжруулсан зуухны утааны ялгаралтын бууралт дээр нэмж бууруулахаар төлөвлөж оруулсан. Хавсралт Б-д МСС-ийн сайжруулсан зуух нь зөвхөн гэр болон байшин сууцанд тохиромжтой, нам даралтын зуух нь зөвхөн байшин сууцанд тохиромжтой, халаалтын зуух нь зөвхөн орон сууцанд тохиромжтой гэсэн хувилбаруудаар тооцсон. Төвийн халаалт ба бусад сайжруулсан халаалтын төхөөрөмжүүдийг зөвхөн орон сууцанд ашиглахаар оруулсан.

Ажиглагчдын санал болгосноор нийслэлийн дотоод орчны агаарын бохирдлын агууламжийн хэмжээ нь халаалтын төхөөрөмж, дам тамхидалт зэргээс голлон хамаарч байна. Ихэнх гэр болон байшин сууцнууд нь нарийн яндантай нүүрс болон модоор галладаг зуухаар халдаг. Эдгээр зуухнууд нь харьцангуй их хэмжээний нарийн ширхэглэгт тоосонцрыг (PM2.5) дотоод болон гадаад орчинд ялгаруулдаг (Ковлин нар, 2005). Мөн түүнчлэн Монгол улс нь тамхи таталтын түвшингөөр өндөр буюу 15-аас дээш настай эрэгтэйчүүдийн 65%, мөн насны эмэгтэйчүүдийн 21% нь тамхи татдаг байна (Байгалмаа нар, 2006). МСС-ийн 2013-2014 онд нийслэлд хийсэн асуумж судалгаанаас нийт байшинд амьдардаг айл өрхийн 58%, гэрт амьдардаг өрхийн 62%-д багаар тооцоход нэг хүн тамхи татаж байна гэсэн дүгнэлт гарсан байна (Сошиал Импакт, 2013а). Орон сууцанд амьдардаг өрхүүдэд энэхүү судалгаа хийгдээгүй боловч ойролцоо түвшинтэй гэж үзэж болох юм.

Судалгааны багийн тооцооноор дотоод орчны агаарын бохирдлын судалгаанд нийт өрхийн хувьд тамхи таталт 60%-тай байгаа нь ДЭМБ-ын стандартаас өндөр байна (ДЭМБ, 2009). Монгол улсад батлагдсан олон нийтийн газар тамхи татахыг хориглосон хууль нь дам тамхидалтын өртөлтийг багасгаж байгаа боловч хувь хүний олон нийтийн бус газар тухайлбал гэртээ байхдаа дам тамхидалтад өртөх байдалд нөлөөлөхгүй юм. Бид судалгаандаа 2014-2024 оны хооронд тамхи таталтын хувийг өөрчлөгдөхгүй байхаар

тооцсон. Дотоод орчны агаарын бохирдолд нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээг гэр, байшин сууцнаас хэмжилт авч тодорхойлсон. Энэ хэмжээг МСС-ийн гэр хороололд амьдардаг өрхүүдийн зуухны төрөл болон дотоод орчны агаарын бохирдол, дам тамхидалтын хэмжээг тогтоох судалгааны хүрээнд тооцсон. Дотоод орчны агаарын бохирдлын хэмжилтийг хийхдээ 2012-2013 оны хооронд гурван удаагийн асуулгаар 1,096 өрхөөс авсан асуумж судалгаанд үндэслэсэн. Улаанбаатрын хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн иргэдээс санамсаргүй түүврийн аргаар асуумж судалгааг авсан. Баянгол дүүрэг хамгийн их агаарын бохирдолтой дүүрэг байсан учраас МСС-ийн сайжруулсан зуухыг тараах гол цэг байсан нь бусад дүүргүүдээс онцлог байлаа. Ингэснээр агаарын бохирдлын хэмжээг хурдан бууруулах тэр тусмаа бохирдол нийт хотоор тарахыг багасах зорилготой байсан юм.

Судалгаанд хамруулах МСС-ийн сайжруулсан зуухыг ашиглаж буй өрхийг сонгохдоо Хаан, Хас банкны жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Ингэхдээ айл өрхүүдийн хаягийг Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны (тухайн үеийн) 2010-2011 оны Улаанбаатар хотын гэр хорооллын бүртгэл мэдээллийн санг ашигласан¹⁵. Дотоод орчны агаарын бохирдлын хэмжилтийг ойролцоогоор 14 цагийн турш хэмжсэн бөгөөд давтан хэмжилтээр нийт 216 айл өрхөд оройноос өглөөний 8:00 цаг хүртэл хэмжилтийн багажуудыг суурилуулж хэмжсэн. Өрхүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгож авсан шалтгаан нь уламжлалт болон МСС-ийн сайжруулсан зуухыг харьцуулсан статистикийн нарийвчилсан үнэлгээ хийх явдал байлаа.

Хүснэгт В1. Дотоод орчны агаарын чанарыг тодорхойлсон өрхийн тоо

	Уламжлалт	Өлзий	Хас	Дөл	Нийт
Гэр	34	36	0	25	95
Байшин	32	32	36	21	121
Нийт	66	68	36	46	216

Гэр ба байшингийн дотоод орчны агаарын хэмжилтийг хийхдээ ижил төрлийн багажийг (TSI DustTrak II Aerosol Monitor and TSI Q-Trak CO/CO₂) тухайн гэр болон байшингийн гол хэсэгт, 1.5 метр өндөрт хүний амьсгалын түвшинд тавьж хэмжсэн. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээг “TSI DustTrak II Aerosol Monitor” багаж, 37мм PTFE (Teflon) 2.0 мкм нүхтэй шүүлтүүр ашиглан хэмжсэн. DustTrak багажийг хүндийн жингийн (gravimetric) дээж цуглуулах аргаар тохируулж хагас үргэлжилсэн (semi-continues) мэдээллийг цуглуулсан. Хагас үргэлжилсэн (semi-continues) CO/CO₂-ийн хэмжилтийг “TSI Q-Trak 7565/7575 CO & CO₂ Monitor” багаж ашиглан хийсэн. Бүх багажны урсгалын хурдыг “Dry Cal flow meter” ашиглан үндсэн стандарт тохиргоо хийн хэмжсэн. Тоосонцорыг цуглуулсан шүүлтүүрийг микробаланстай өрөөнд хэмжилтийн өмнө болон хойно 48 цагийн дотор жигнэж, нийт 9 хэсэг хэмжилтийн мэдээний бохирдлын хэмжээг цуглуулсан.

¹⁵ Үндэсний Статистикийн Газрын Дарга болон Хөдөлмөрийн Сайдын хамтарсан тушаалаар “аргачлал, асуултын форм болон асуултыг бөглөх зааварчилгаа”-г батлуулсан – 2010 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр.

Эдгээр хэмжсэн өгөгдлөөс дараах загвар ашиглан бохирдлын хэмжээг тооцсон. Ингэхдээ зуухны төрлөөс хамаарсан утааны ялгаралт болон дам тамхидалтаас үүдсэн дотоод орчны агаарын хэмжээг тооцсон (Хүснэгт В2).

$$\text{Дотоод } PM_{2.5} = \beta_0 + \beta_1 \times \text{Уламжлалт} + \beta_2 \times \text{Дам тамхидалт}$$

Дотоод $PM_{2.5}$ Дотоод орчны агаарт агуулагдах нарийн ширхэглэгт тоосонцорын ($PM_{2.5}$) дундаж хэмжээ ($\text{мкг}/\text{м}^3$ шөнийн хэмжилтээр),

β_0 МСС-ийн сайжруулсан зуухтай өрхийн дотоод орчны агаарт агуулагдах $PM_{2.5}$ -ын дундаж хэмжээ,

β_1 Уламжлалт болон МСС-ийн сайжруулсан зуухтай өрхийн дотоод орчны агаарт агуулагдах $PM_{2.5}$ -ын дундаж хэмжээ,

β_2 Тамхи татдаг болон татдаггүй өрхийн дотоод орчны агаарт агуулагдах $PM_{2.5}$ -ын дундаж хэмжээний зөрүү.

Уламжлалт зуухтай болон дам тамхидалтыг 0=үгүй; 1=тийм гэж авна. Лонжитудинал дотоод орчны агаарын бохирдол нарийн ширхэглэгт тоосонцорын ($PM_{2.5}$) хэмжилтэд өөр судалгаанд бас хамрагдсан айл өрхүүд орсон ба эдгээр айл өрхүүдэд шөнийн турш хэмжилт хийсэн¹⁶. Шөнийн турш хийгдсэн хэмжилт нь 24 цагийн дундажтай тэнцэх ба 1 дүгээр сараас 4 дүгээр сарын хооронд дунджийг нь бодсон.

Дотоод орчны агаарын бохирдлын бууралт нь гэрийн хэмжилтийн регрессийн дүнгээс гарсан ба гэр, байшин сууцыг ижил байдлаар тооцсон (Хүснэгт В2, В3). Шөнийн цагаар дотоод орчны агаарын бохирдолын нарийн ширхэглэгт тоосонцорын ($PM_{2.5}$) дундаж хэмжээг гэр, байшин сууцнаас ижил аргачлалаар хэмжсэн ($14-18$ болон $13-17 \text{ мкг}/\text{м}^3$). Гэсэн хэдий ч уламжлалт зуухтай байшинд амьдардаг айл өрхүүдийн дотоод орчны агаарын бохирдлын дундаж хэмжээг нь бусдаасаа бага байсан. Нийт хэмжилтээс гарсан тоон утга, үр дүнгүүд нь харилцан ялгаатай байсан бөгөөд гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь тамхи татдаг айл өрхүүдийг тусад нь хэмжихэд гэр, байшин сууцтай айл өрхүүдийн хэмжилтийн үр дүн адил байлаа (13 болон $14 \text{ мкг}/\text{м}^3$). Уламжлалт зуухтай байшинд амьдардаг айл өрхүүдийн дотоод орчны агаарын бохирдлын хэмжээг уламжлалт зуухтай гэрт амьдардаг болон МСС-ийн сайжруулсан зуухтай байшинд амьдардаг айл өрхүүдээс бага байгаа нь дараах үндсэн шалтгаантай байж болно:

Үүнд:

1. Уламжлалт зуухтай байшинд амьдардаг айл өрхүүдийн нарийн ширхэглэгт тоосонцорын ($PM_{2.5}$) нэг өдрийн ялгаралт нь гэр сууцныхаас их, МСС-ийн сайжруулсан зуухтай айл өрхүүдээс харьцангуй их.
2. Дотоод орчны агаарын СО-ийн хэмжээ нь бүх төрлийн зуухтай гэрт амьдардаг өрхүүдэд их, уламжлалт болон МСС-ийн сайжруулсан зуухтай өрхүүдийн бохирдлын зөрүү өндөр.

¹⁶ Дрю Хилл, Руфус Эдвардс, Кирк Смит нар Монгол улсын нийслэлийн гэр хорооллын нүүрсээр галладаг зуух ба нарийн ширхэглэгт тоосонцорын ($PM_{2.5}$) лонжитудинал үнэлгээ судалгааг үргэлжлүүлэн хийж байна.

Хүснэгт В2. Дотоод орчны агаарын бохирдлын загварчлал. МСС-ийн сайжруулсан зуух болон Уламжлалт зуух – Гэр сууцанд

	Коэффициент (мкг/м ³)	Стандарт алдаа (мкг/м ³)	P утга
МСС-ийн сайжруулсан зуух	124.7	19.8	1.102 e-8
Уламжлалт зуух	23.4	24.7	0.346
Гэртээ тамхи татдаг өрх	40.4	24.6	0.104

Загварын p утга: 0.113, n = 94 гэр сууц

Дотоод орчны агаарын бохирдлын коэффициент нь 2013-2014 оны өвлийн улиралд гэр сууцанд хэмжсэн дүн юм (18.00-08.00 цагийн хооронд)

Бид яагаад уламжлалт зуухтай байшин сууцны дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ нь бусад уламжлалт зуухтай гэр сууц болон МСС-ийн сайжруулсан зуухтай байшин сууцнаас бага гарсныг тайлбарлах боломжгүй байлаа. Энэ нь багажийг буруу газар байрлуулсан, тухайн сууц олон өрөө, тасалгаатай бол нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ялгаралт бусад өрөөндөө тархсан зэргээс шалтгаалж болно. Иймд олон өрөө тасалгаатай, уламжлалт зуухтай байшин сууцны судалгааг цаашид үргэлжлүүлэх шаардлагатай юм.

Тодруулга: МСС-ийн сайжруулсан зуухыг уламжлалт зуухтай харьцуулахад гэр сууцны дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ нь 16%-аар буурч байна. Мөн түүнчлэн гэр ба байшин сууцтай айл өрхүүдийн дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ адил хэмжээгээр буурсныг загварчлалаар харуулав. Нам даралтын зуух болон хагас коксжсон нүүрсэн зуухын талаар олон нийт уламжлалт зуух илүү гэж дүгнэж байна. Гэвч бид бодитой хэмжилтгүйгээр түүнийг нотлох боломжгүй юм. Эдгээрийг цэвэр сайжруулсан халаалтын төрөл гэж үзэж болохгүй тул МСС-ийн сайжруулсан зуухтай дүйцүүлэн тооцсон. “Ирээдүйн шинэ технологийн зуух” нь зах зээлд гарч ирнэ гэж үзэн эдгээр зуух нь уламжлалт зуухнаас МСС-ийн сайжруулсан зуухны бууруултан дээр мөн адил хувиар нэмж бууруулахаар тооцлоо. Ирээдүйн шинэ технологийн зуух нь МСС-ийн сайжруулсан зуухнаас ~16%-аар буурсан үзүүлэлттэй (105 мкг/м³) байхаар тооцлоо.

Гадаад орчны тоосонцорын нэвчилт

Гадаад орчны тоосонцорын дотоод орчин руу орох нэвчилт нь дотоод орчны агаарын бохирдлын агууламжид ихээхэн нөлөөлдөг болохыг олон судлаачид хүлээн зөвшөөрсөн байдаг (Аллен нар, 2012). Гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дотоод орчинд үзүүлж буй нөлөөг хамрах хүрээний нэвчилтийн коэффициент (F_{inf} – factor of infiltration efficiency) гэдэг үзүүлэлтээр хэмждэг (Докери нар, 1981). Нэвчилтийн коэффициент нь гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламж дотоод орчинд нэвтрэн, тэндээ үлдэж буй хувь юм. Нэвчилтийн коэффициент нь дотоод орчин дахь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) чухал эх үүсвэр болох учир тоосонцорын хэмжээ болон эрүүл мэндэд нөлөөлөх байдлыг нарийн тооцох шаардлагатай.

Байшин болон орон сууцанд нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жилийн дундаж нэвчилтийн коэффициентийг зарим томоохон хотуудад хийсэн хэмжилтийг багтаасан

EXPOLIS судалгаанаас авч ашиглалаа (Хэннинен нар, 2004). Бид судалгаандаа Улаанбаатар хоттой ижил уур амьсгалтай EXPOLIS судалгаанд хамрагдсан Финланд улсын Хельсинк хотын тайланд дурьдсан дундаж нэвчилтийн коэффициентийг ашиглалаа ($F_{inf}=59\%$). EXPOLIS судалгаагаар бүтэн жилийн турш олон тооны өрхөд 48 цагийн нэвчилтийн хэмжээг тооцсон байдаг. Энэхүү судалгаа нь өөр өөр улиралд байшин сууц болон олон давхар орон сууцны (58% нь олон давхар орон сууц) аль алиныг хамруулсан тул эдгээр үзүүлэлт нь Улаанбаатар хотын байшин сууц болон орон сууцны жилийн дундаж нэвчилтийн коэффициентийг төлөөлж чадахуйц гэж бид үзсэн (Жантунен нар, 1998). Иймд бидний судалгаа нь бүтэн жилийн туршид байшин сууц болон орон сууцанд тооцсон нэвчилтийн коэффициентийг ашигласан. Энэ хэмжээ нь ижил уур амьсгалтай, орчин нь төстэй сууцанд тодорхойлсон F_{inf} -тэй ойролцоо байлаа (Лонг нар, 2001).

Гэр сууцанд өвөл, зуны улиралд гэр сууцны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) нэвчилтийн коэффициентийг ялгаатай байдлаар тооцов. Гадаад болон дотоод орчин дахь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламжийг хамгийн ихээр тэнцвэржүүлэгч нь цонх, хаалга онгойлгох болон дотоод орчны ялгаруулалтын эх үүсвэрийг арилгах үед ихэсдэг болох нь ажиглагдав (Аллен нар, 2012). Гэрийн хаалга болон тооныг зуны улиралд гол төлөв онгорхой орхидог бөгөөд энэ нь агааржуулалтын хэмжээг өндөр байлгаж, гэрийн бүрээсээр дамжих агаарын урсгалтай холбоотой шүүлтийг үндсэндээ үгүй болгодог гэж бид үзсэн. Түүнчлэн зуны улиралд зуух тэр бүр ашиглахгүй учир гэр дотор тамхинаас өөр дотоод орчны агаарын бохирдлын томоохон үүсвэр байхгүй гэж үзсэн. Энэ нь бусад нутаг дахь өвлийн болон зуны улирлын нэвчилтийн коэффициенттэй төстэй байна (Лонг нар, 2001). Иймд бид зуны улирлын нэвчилтийн коэффициентийг 100% гэж тооцлоо ($F_{inf}=100\%$). Бид өвлийн улиралд Монгол улсын ШУТИС-ийн судлаачдын тогтоосон Монгол гэрийн хаалганы нэвчилтийн коэффициентийг ашиглалаа ($F_{inf}=70\%$).¹⁷ Энэ судалгаагаар энгийн дулаалга, ялаа шумуулны тор бүхий монгол гэрийн хаалганы хувьд агаарын солилцооны түвшин $n50$ байгааг харуулсан ба үүнийг Шерманы тодорхойлсон аргаар, байгалийн агаарын солилцооны түвшинд шилжүүлэн тооцсонтой ижил байлаа (1987). Агаарын солилцооны түвшинг Вилльямсын муруйг (Вилльямс нар, 2003) ашиглан нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) нэвчилтийн коэффициентийг ойролцоогоор шилжүүлэн тооцсон. Шатлал тус бүрийн дүнг Хүснэгт В4-т харуулав. Энэ нь хэдийгээр шилжүүлэн тооцох төгс арга биш боловч илүү сайн өгөгдөл одоогоор байхгүй нөхцөлд өвлийн улиралд Монгол гэр дэх нэвчилтийн коэффициентийг тооцох харьцангуй боломжит үзүүлэлт гэж бид үзлээ.

Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) нэвчилтийн хэсгүүдийг бүх орон сууц болон халаалтын цэвэр эх үүсвэртэй байшин, гэрийн хувьд ашигласан. Бид МСС-ийн сайжруулсан зуух, уламжлалт зуух, хагас коксжсон нүүрсэн зуух болон нам даралтын зуухтай гэр болон байшин сууцны дотоод орчны бохирдлын хэмжээг тогтоохдоо нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) нэвчилтийг ижил байхаар тооцлоо.

¹⁷ Мөнхбаяр Б., (хэвлэгдэхээр бэлтгэж буй). Монгол гэрийн хаалганы туршилт. 2013 оны 12 дугаар сар.

Хүснэгт В4. Өвлийн улиралд гэрийн хаалгаар нэвтрэх агаарын нэвчилтийн өгөгдөл болон шилжүүлсэн томъёоны оролт, гаралтын тооцоо.

(Шерман нар, 1987; Вильямс нар, 2003)¹⁸

Агаарын солилцоо/цагт @ n50 ¹⁹	Байгалийн агаарын солилцооны тооцоо, өөрчлөлт /цаг: ACH=(ACH@n50)/20 (Шерман нар, 1987)	Нэвчилтийн коэффициент хөрвүүлэлт: Finf=0.5571+0.1726ln (нийт хэмжээ байгалийн агаарын солилцооны түвшин) (Вильямс нар, 2003)
45	2.25	0.697

Дотоод орчны агаарын бохирдол

Дээр дурдсан тоо баримт, мэдээлэлд үндэслэн Төлөв 2013-ын дотоод орчин дахь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) 24 цагийн дундаж хэмжээг сууцны төрөл, улирлаар тооцон гаргалаа. Гадаад орчны нэвчилтийн коэффициентийг улирал, хоногийн ялгаатай байдлаар нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дундаж хэмжээгээр тооцсон. Гадаад орчны загвар болон дундажлах аргыг тайлангийн холбогдох хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно. Гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дундаж хэмжээг гадаад орчны загвараас гаргасан бөгөөд хүн амын оршин сууж буй сууцны төрлөөр (гэр, байшин, орон сууц), газарзүйн байршлын хэмжээгээр (шоо дөрвөлжин нүдээр) харьцуулан тооцсон. Зуны цагт халаалт ашигладаггүй гэж үзсэн ба дээр дурдсан загварт дам тамхидалтын дотоод орчин дахь нарийн ширхэглэгт тоосонцорыг (PM2.5) зун, өвлийн улирлын аль алинд нь ижил байхаар тооцлоо. Улирлын агаарын бохирдлын хэмжээг сууцны төрөл, зуухны төрөл, тамхидалтын байдлаар нь Хүснэгт В5 ба В6-д харуулав.

¹⁸ Мөнхбаяр Б., (хэвлэгдэхээр бэлтгэж буй). Монгол гэрийн хаалганы туршилт. 2013 оны 12 дугаар сар.

¹⁹ Мөнхбаяр Б., (хэвлэгдэхээр бэлтгэж буй). Монгол гэрийн хаалганы туршилт. 2013 оны 12 дугаар сар.

Хүснэгт В5. Сууцны болон халаалтын төрлийг тамхи таталтын байдлаар гаргасан өвлийн улирлын дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ

	Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ – тамхи татдаггүй (мкг/м ³)	Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ – тамхи татдаг (мкг/м ³)
Төлөв 2013		
МСС-ийн сайжруулсан зуух	125	165
Нам даралтын зуух	125	165
"Цэвэр" халаалт	-	-
Гэр	106	146
Байшин	94	134
Орон сууц	89	129
Хувилбар 1		
МСС-ийн сайжруулсан зуух	125	165
Нам даралтын зуух	125	165
Ирээдүйн шинэ технологийн зуух	105	145
"Цэвэр" халаалт		
Гэр	41	81
Байшин	37	77
Орон сууц	34	74
Хувилбар 2		
"Цэвэр" халаалт		
Гэр	1	41
Байшин	1	41
Орон сууц	1	41

Хүснэгт В6. Сууцны болон халаалтын төрлийг тамхи таталтын байдлаар гаргасан зуны улирлын дотоод орчны агаарын бохирдлын агууламж

	Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ – тамхи татдаггүй (мкг/м ³)	Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ – тамхи татдаг (мкг/м ³)
Төлөв 2013		
Гэр	7	47
Байшин	4	44
Орон сууц	6	46
Хувилбар 1		
Гэр	1	41
Байшин	1	41
Орон сууц	1	41
Хувилбар 2		
Гэр	1	41
Байшин	1	41
Орон сууц	1	41

МСС-ийн сайжруулсан зуухыг тарааснаар утааны ялгаралт буурсан хэдий ч, дотоод орчин дахь агаарын бохирдол хангалттай буураагүй болно. Гэр, сууцны дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ хэвээр байгаа нь ДЭМБ-ын дотоод орчны агаарын чанарын зорилтот хэмжээнээс (35 мкг/м³) 3.6 дахин өндөр, ДЭМБ-ын агаарын чанарын зөвлөмжид заасан хэмжээнээс (10 мкг/м³) их байсаар байна. Төлөв 2013-ын хувьд МСС-ийн сайжруулсан зуухны нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэн өвлийн улиралд дотоод орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээг 18%-аар бууруулж буй боловч дотоод орчны бохирдол өндөр хэвээр байна. Гэхдээ уг хөтөлбөр нь дотоод орчинд гаргаж буй ялгаруулалтыг хамгийн бага байлгах зориулалттай зуухыг сонговол өртөлтийг ихээхэн бууруулж, агаарын бохирдлоос шалтгаалсан өвчнийг бууруулах боломжтой. Хувилбар 1-ийн хувьд байгалийн хий, цахилгаан зуух болон төвлөрсөн халаалтыг ашиглахын зэрэгцээ ДЭМБ-ын агаарын чанарын зөвлөмжийн үзүүлэлтээс нилээд доогуур, дотоод орчны агаарын бохирдлын хэмжээг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр утааны ялгаралт харьцангуй бага байна. Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээг тооцохдоо зөвхөн зуух болон утааны ялгаруулж буй бохирдол, гадаад орчноос нэвтэрч буй хэмжээг авч үзэхээс гадна дотоод орчны агаарын бохирдлын хэмжээнд харьцангуй бага нөлөөлдөг хоол хүнс болон дотоод орчин дахь бусад эх үүсгэврийг (лаа, хүж гэх мэт) оруулсангүй. Гэвч тэдгээр нь гэрт тамхи татдаг хүн байдгаас бусад тохиолдолд хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзлээ.

НИЙТ ӨРТӨЛТИЙН ТООЦОО

Улаанбаатар хотын хэмжээнд нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийн жилийн дундаж хэмжээг судалгааны хувилбар тус бүрээр шаталсан байдлаар тооцсон. Энэ загвар нь дотоод болон гадаад бичил орчны үндсэн эх үүсгэврүүд, орчин тус бүрт хүн амын өнгөрүүлж буй хугацаа болон тоосонцорын нэвчилтийг тооцож гаргасан. Түүнчлэн иргэдийн бичил орчин тус бүрт байх хугацааг насны бүлгээр ялгаатай байдлаар үнэлсэн. Энэ хэсэгт нарийн ширхэглэгт тоосонцорт (PM2.5) өртөж буй хүн амын тооцоог хувилбар тус бүрт үйл явц, тэнцэл, гол таамаглалуудад тусган хүн амд жинлэсэн байдлаар тооцсон.

Эх үүсвэр

Дотоод болон гадаад орчны эх үүсгэврүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт Б болон В-ийн өртөлтийн үнэлгээнд тусгав. Ерөнхийдөө дотоод орчны агаарын бохирдлын гол эх үүсвэрт халаах зуух болон тамхины утаа (дам тамхидалт) орох бол гадаад орчны эх үүсвэрт өрхийн зуух, нам даралтын зуух, хагас коксжсон нүүрсэн зуух, халаалтын зуух, автомашин, дулааны цахилгаан станцууд багтаж байна. Эдгээр эх үүсгэврүүдийн таамаглалын талаар өмнөх хэсгүүдэд дурьдсан бөгөөд дам тамхидалтын утааны дотоод орчны өртөлтөд нөлөөлөх байдлыг хувилбар тус бүрээр, улирлын болон жилийн дундаж агууламжид хэрхэн нөлөөлж байгааг доор тайлбарлав.

Өртөлтийн загвар

Бид судалгааны хувилбар тус бүрийн хувьд хүн амд жинлэсэн жилийн дундаж үзүүлэлтийг тооцох шаталсан цуврал загварыг ашигласан. Эдгээр тоон үзүүлэлтийг улирлын (зуны ба өвлийн) болон хоногийн (шөнийн болон өдрийн) хугацаанд тооцсон бичил орчны өртөлтөөр тодорхойлсон.²⁰

Хамгийн өндөр түвшинд хүн амын 2 үндсэн дэд бүлэг тус бүрийн жилийн дундаж өртөлтийн хүн амд жинлэж тооцлоо (Загвар А). Хүн амын 24 үндсэн дэд бүлэгт:

- А. Хүүхэд (4 хүртэлх насны)
- Б. Асран хамгаалагч (5-аас доош насны хүүхэд тутамд 1)
- В. Бусад (5-аас дээш насныхан)

Дээрх насны бүлэг тус бүрийг дараах зуухны төрөл бүхий айл өрхүүдэд тооцлоо. Үүнд:

1. МСС-ийн сайжруулсан зуух болон хагас коксжсон нүүрсэн зуухтай гэр
2. Ирээдүйн технологийн зуухтай гэр
3. Цэвэр халаалтын зуухтай гэр²¹
4. МСС-ийн сайжруулсан зуух болон хагас коксжсон нүүрсэн зуухтай байшин
5. Нам даралтын зуухтай байшин

²⁰ Өвлийн сарууд нь 10-3 дугаар сар. Зуны сарууд нь 4-9 дүгээр сар. Өдрийн цаг нь 8.00-18.00, шөнийн цаг нь 18.00-8.00 гэж тодорхойлсон. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хүн амд жинлэх хоногийн цагийн хуваарьт тусгав.

²¹ "Цэвэр" халаалтын зуух гэдэгт шаталтын үр дүнд мэдэгдэхүйц нарийн ширхэглэгт тооцсонцор (PM2.5) ялгардаггүй зуухыг тооцно. Жишээ нь хийн, цахилгаан зэрэг зуухны төрлүүд орно.

6. Ирээдүйн технологийн зуухтай байшин

7. Цэвэр халаалтын зуухтай байшин буюу орон сууц

Тодорхой хүн амын дэд бүлгийн жилийн дундаж өртөлтийг улирлын өртөлтийн дундажаар тооцсон (Загвар Б). Хүн амын дэд бүлгийн улирлын дундаж өртөлтийг дотоод болон гадаад орчин дахь өртөлтийн дундажийг цаг хугацааны үйлдлээр харьцуулан тооцсон (Загвар В ба Г).

Загвар тус бүрийн хувьд “A” нь age буюу өртөлтийг үнэлсэн хүн амын үндсэн дэд бүлэг, “H” нь household буюу өрхийн хэрэглэж буй зуухны төрөл, “DT” буюу дам тамхидалт, “S” нь seasons буюу улирал (зун, өвөл), “D” нь daytime буюу өдрийн цаг, “N” нь night буюу шөнийн цаг, “in” нь indoor буюу дотоод бичил орчин, “out” нь outdoor буюу гадаад бичил орчин, “PM” тухайн бичил орчин дахь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламж ($\text{мкг}/\text{м}^3$), “%t” нь тухай бичил орчинд “D,S” эсвэл “N,S”-д байсан хугацааны эзлэх хувь, “IF” нь infiltration factor буюу сууцны зуухны төрлийн нэвчилтийг тооцсон.

$$\text{Хүн амд жинлэсэн жилийн дундаж өртөлт} = \sum \left(\% \text{ Хүн ам}_{A.H.} \times \text{Жилийн дундаж өртөлт}_{A.H.} \right)$$

Загвар А. Хүн амд жинлэсэн жилийн дундаж өртөлтийг тооцохдоо нийслэлийн нийт хүн амыг оруулан тооцлоо.

$$\text{Жилийн дундаж өртөлт}_{A.H.} = \frac{(\text{Өвлийн дундаж}_{A.H.S.}) + (\text{Зуны дундаж}_{A.H.S.})}{2}$$

Загвар Б. Хүн амд жинлэсэн жилийн дундаж өртөлтийг тооцохдоо өвлийн болон зуны улирлын нийт өртөлтийн дундажаар тооцлоо.

Улирлын дундаж
өртөлт $_{A.H.}$

$$= (\%t_{in,D,S} \times \text{Улирлын өдрийн дундаж дотоод PM2.5 өртөлт}_{A.H.S}) + (\%t_{in,N,S} \times \text{Улирлын шөнийн дундаж дотоод PM2.5 өртөлт}_{A.H.S}) + (\%t_{out,D,S} \times \text{Улирлын өдрийн дундаж гадаад PM2.5 өртөлт}_{A.H.S}) + (\%t_{out,N,S} \times \text{Улирлын шөнийн дундаж гадаад PM2.5 өртөлт}_{A.H.S})$$

Загвар В. “А” хүн амын дэд бүлгийн насны болон “Н” өрхийн ашиглаж буй зуухны төрлөөс хамаарсан улирлын дундаж өртөлтийн хэмжээг тооцохдоо дээрх загварыг ашигласан. Улирлын дундаж өртөлтийг зуны болон өвлийн улиралуудад тооцсон. “%t” нь “D,S” эсвэл “N,S” хугацаанд тухайн бичил орчинд зарцуулсан хугацааны хувиар тооцлоо.

- I. Улирлын өдрийн дундаж дотоод PM2.5 өртөлт $_{A.H.S}$ = $PM_{in, өвөл, S} + (IF_H \times PM_{out, H, D, S})$
- II. Улирлын шөнийн дундаж дотоод PM2.5 өртөлт $_{A.H.S}$ = $PM_{in, өвөл, S} + (IF_H \times PM_{out, H, N, S}) + (PM_{in, ДТ, S})$
- III. Улирлын өдрийн дундаж гадаад PM2.5 өртөлт $_{A.H.S}$ = $PM_{out, H, D, S}$
- IV. Улирлын шөнийн дундаж гадаад PM2.5 өртөлт $_{A.H.S}$ = $PM_{out, H, D, S}$

Загвар Г. Хүн амын дэд бүлэг “А”, улирал “S”, зуухны төрөл “H” тус бүрт дотоод болон гадаад орчны өдрийн болон шөнийн өртөлтийг тооцоход дээрх загварыг ашиглалаа.²²

Хүн амд жинлэсэн өртөлт ба Хоногийн цагийн хуваарь

Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жилийн дундаж өртөлтийг хоёр шатлалаар хүн амд жинлэн тооцлоо. Загвар Г-ийн хувьд гадаад орчны дундаж өртөлтийг ерөнхий гурван төрлийн сууцан дахь (гэр, байшин, орон сууц) хүн амын хувьд улирал болон хоногийн цагийн (өдөр ба шөнийн) хуваарийн ялгаатай байдлаар тус бүрт нь тооцон гаргасан. Эдгээр өртөлтийг Багануур болон Багахангай гэсэн хоёр дүүргээс бусад дүүрэгт тодорхой төрлийн сууцан дахь хүн амд жинлэсэн гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийг загвар дахь хэсэг тус бүрийн гадаад орчны дундажаас тооцсон. Дээрх хоёр дүүргийг гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) загварт оруулаагүй бөгөөд эдгээр дүүргийн гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дундаж

²² Зуух болон нам даралтын зуухтай гэр, байшингийн хувьд, “PM_{in}”-ыг тооцохдоо өвлийн улирлын нэвчилтийн факторыг 0-тэй тэнцүү гэж тооцлоо (IF=0).

өртөлтийн улирал тус бүрийн хүн амд жинлэсэн өртөлтийг жирийн аравтын хувиар (аравны нэгт) авч үзсэн болно (Хүснэгт Г1).²³ Загвар А-д нийслэлийн нийт хүн амын жилийн дундаж өртөлтийг тооцохдоо хүн амын дэд бүлгийн эзлэх хувьтай дүйцүүлэн тооцлоо.

Хүснэгт Г1. Гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дундаж өртөлтийг аравтын хувиар илэрхийлсэн байдал (мкг/м³) – Нийт хүн амд жинлэсэнээр

Хувилбар	10 th %ile Өвлийн өдөр	10 th %ile Өвлийн шөнө	10 th %ile Зуны өдөр	10 th %ile Зуны шөнө
2014 – Суурь түвшин	49.8	69.2	1.3	1.9
2024 – Төлөв 2013	59.9	79.4	2.4	3.3
2024 – Хувилбар 1	22.9	29.8	0.4	0.6
2024 – Хувилбар 2	0.6	0.7	0.2	0.3

Хүснэгт Г1-д нийслэлийн нийт хүн амд жинлэсэн гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) дундаж өртөлтийг аравтын хувийг тооцсон байдлаар үзүүлээ.

Хоногийн цагийн хуваарийг тооцсон боловч хүн амаар бус харин дотоод болон гадаад орчинд зарцуулж буй хугацаагаар нь жинлэж тооцлоо. Монголчуудын хоногт хийж буй ажлын бүтцийн талаарх мэдээлэл харьцангуй бага байсан. Иймээс бид МСС-ийн 2013 онд хийсэн өвлийн улирлын талаарх судалгаагаар Улаанбаатар хотын гэрт болон байшинд амьдардаг МСС-ийн сайжруулсан зуух ашигладаг хүүхэд, насанд хүрэгчдийн гэрийн дотор болон гадаа зарцуулж буй цагийг судалсан дүнг ашигласан. Энэхүү судалгааны дүнгээр Улаанбаатар хотын оршин суугчдын өвлийн улирлын амьдралын хэв маягийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн боловч эдгээр нь дүүрэг, сууцны төрөл, зуухны төрөл, улирлын шинж зэрэг хувьсагчдыг бүрэн илэрхийлэх боломжгүй тул эдгээр мэдээллийг бид судалгаандаа шууд ашиглах боломжгүй байлаа. Харин Улаанбаатар хотын нийт хүн амын өвлийн улирлын амьдралын хэв маягийн талаарх ойлголтыг тогтоохын тулд эдгээр судалгааны дүнг холбогдох тайлбар, мэргэжилтний саналтай хамтатган авч үзлээ. Өвлийн улирлын амьдралын хэв маягаас бид зуны улирлын амьдралын хэв маягийн талаарх үндэслэл бүхий таамгийг гаргав. Хүүхэд (насны бүлгийнхэн), тэдгээрийн асран хамгаалагчид, бусад (5-аас дээш насны бүлэгийнхний) хувьд хоногийн цагийн хуваарийг тоогоор үзүүлэв (Хүснэгт Г2). Хүүхэд болон тэдний асран хамгаалагчид ихэнх цагаа гэртээ өнгөрөөдөг гэж үзсэн бөгөөд жилийн турш тэд 100% дотоод орчинд байдаг гэж тооцлоо.²⁴ Бусад буюу насанд хүрэгчдийн хувьд амьдралын хэв маягийг нь хоногийн хоёр хэсэгт хувааж тооцлоо. Үүнд ажил, сургуульдаа явахаар гэрээсээ гадуур байдаг 10 цаг (өдрийн цаг буюу 8:00-18:00 цаг), болон гэртээ өнгөрүүлдэг 14 цаг (шөнийн цаг буюу 18:00-8:00 цаг) байна.

²³ Багануур, Багахангай дүүргүүд нь нийслэлээс харьцангуй алслагдсан, хөдөө нутагт байрладаг бөгөөд гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт бага байдаг гэж үзэв.

²⁴ Хэдийгээр бодит байдал үүнээс арай өөр боловч зун цагт гадаад болон дотоод орчинд цонх, хаалгаа онгойлгох, гэрийн хаяа зэргээр агааржуулалт сайн байх учир зун цагийн нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт ойролцоо байна гэж үзлээ.

Хүснэгт Г2. Улирлын болон хоногийн ялгаатай үеүдийн дотоод болон гадаад орчинд өнгөрүүлж буй хугацаа (хүн амын үндсэн дэд бүлгээр)

	Дотоод орчин	Гадаад орчин
<i>Өдрийн цаг – Өвөл</i>		
Хүүхэд	1.00	0
Асран хамгаалагч	1.00	0
Насанд хүрэгчид	0.75	0.25
<i>Шөнийн цаг – Өвөл</i>		
Хүүхэд	1	0
Асран хамгаалагч	1	0
Насанд хүрэгчид	1	0
<i>Өдрийн цаг – Зун</i>		
Хүүхэд	1	0
Асран хамгаалагч	1	0
Насанд хүрэгчид	0.75	0.25
<i>Шөнийн цаг – Зун</i>		
Хүүхэд	1	0
Асран хамгаалагч	1	0
Насанд хүрэгчид	1	0


Хүн амын хоногт цагаа өнгөрүүлж буй бичил орчин нь нийгэм-хүн амзүйн бүлэг, улирлын байдлаар ялгаатай гэж үзсэн боловч ийнхүү ангилах тоо баримт бэлэн байхгүй учир эдгээр ялгаатай байдлыг тооцох нийтлэг таамаглалыг дэвшүүлэн загварчиллаа. Хүн амын түвшинд өдрийн цагаар дотоод орчинд өнгөрүүлж буй дундаж хугацааг 75%, өдрийн цагаар гадаад орчинд өнгөрүүлж буй дундаж хугацааг 25% гэж тус тус үзэв.^{25,26} Дотоод орчинд өдрийн болон шөнийн цагаар өнгөрүүлж буй хугацааны талаар тодорхой мэдээлэл байхгүй тул, бид хүүхэд өдрийн болон шөнийн цагийг 100% дотоод орчинд өнгөрүүлдэг гэж авч үзлээ.

²⁵ Нийслэлд гадаад орчинд ажилладаг барилга, хөдөө аж ахуй, уул уурхай, тээвэр зэрэг салбар их байдаг учир өдрийн цагаар гадаад орчинд өнгөрүүлж буй хугацаа нь 25 хувиас илүү байх магадлалтай боловч бид хамгийн бага хуваарь тооцлоо (Чилхаасүрэн, Баасанхүү, 2010).

²⁶ Дотоод орчин дахь өртөлтийг тооцохдоо гэрээсээ өөр газар дотоод орчинд өнгөрүүлж буй өртөлт нь гэрийн дотоод орчин дахь өртөлттэй адил гэж үзлээ.

Насанд хүрэгчдийн ангилалд багтах хүн амын тодорхой хэсэг нь хүүхэд харах үүрэг хүлээдэг гэж үзэн, нэг хүүхдэд нэг асран хамгаалагч ногдохоор тооцсон. Тэднийг хүүхэдтэй адил амьдралын хэв маягтай гэж үзлээ. Хүүхэд, тэдний асран хамгаалагч, бусад (насанд хүрэгчид) гэж ангилан тэднийг өрхөд жигд хуваарилагдсан байдаг гэж үзсэн бөгөөд тухайлбал нийт хүн амын тодорхой хэсэг нь гэрт амьдардаг бол мөн хэмжээний хүүхэд, тэдний асран хамгаалагч, бусад (насанд хүрэгчид) гэсэн насны бүлгийн хүмүүс гэрт амьдардаг гэж тооцсон.

Хувилбар тус бүр дэх хүн амын бүлгийн өртөлт



Зураг Г1. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жилийн дундаж хэмжээний бүтэц (сууцны төрлөөр)

ХАВСРАЛТ Д.

ЭРҮҮЛ МЭНДИЙН АЧААЛАЛ БОЛОН ҮР АШГИЙН ТООЦОО

Өнөөгийн байдал

Монгол улсын 1000 хүн амд ногдох голлох өвчлөлүүдийг Алдагдсан Амьдралын Жилүүдээр (ААЖ) харууллаа (Хүснэгт Д1). Үүнд: Зүрхэнд цус хомсрох эмгэг, Амьсгалын доод замын цочмог халдвар, шигдээс өвчнүүд нь нийт ААЖ-ийн гуравны нэг орчмыг эзэлж байна. Бусад өвчлөлүүд үлдсэн хувийг эзэлж байна. (Дэлхийн Өвчлөлийн Ачааллын Судалгаа, 2014)

Хүснэгт Д1. Монгол Улсын зонхилох өвчлөлийг Алдагдсан Амьдралын Жилүүдээр (ААЖ) эрэмбэлсэн нь, 2010 он

	Өвчний төрөл	ААЖ	Хувь
1	Зүрхэнд цус хомсрох эмгэг *	96	11.8
2	Амьсгалын доод замын халдвар *	87	10.6
3	Шигдээс *	78	9.5
4	Нярайн тархины эмгэг	41	5.0
5	Зам тээврийн осол	34	4.2
6	Элэгний хатуурал	32	3.9
7	Элэгний хавдар	30	3.6
8	Төрөлтийн өмнөх хүндрэлүүд	28	3.5
9	Төрөлхийн гаж хөгжил	25	3.1
10	Сүрьеэ	20	2.4
11	Бөөрний архаг өвчин	19	2.3
12	Ходоодны хавдар	16	2.0
13	Амиа хорлох	16	2.0
14	Зүрхний хэрх өвчин	14	1.8
15	Хүчирхийлэл	14	1.7
16	Гэмтэл	14	1.7
17	Уушгины архаг бөглөрөлтөт өвчин *	13	1.5
18	Уушгины хавдар *	12	1.5

* Судалгааны тооцоонд оруулсан өвчлөлүүд

Эх сурвалж: <http://www.healthmetricsandevaluation.org/gbd/country-profiles>

Загварт ашигласан аргачлалын тайлбар

Хувилбар тус бүрийн хүрээнд эрүүл мэндийн нөлөөллийг өвчний ангиллаар болон насны бүлэг тус бүрт ялгаатай байдлаар тооцлоо. Эрүүл мэндийн нөлөөллийг тооцох аргачлалыг Бэркэлэй дэх Калифорнийн Их сургууль болон Нэгдсэн Үндэстний Сангийн эрдэмтэд хамтран боловсруулсан (Пилларисетти нар, 2013). Мөн бид судалгаандаа Өрхийн Агаарын Бохирдлын Интерванц Аргын (ӨАБИА – НАРІТ) шинэчилсэн хувилбарыг

ашигласан. Энэхүү аргыг ашиглан 2014-2024 оны хооронд хийсэн хувилбар тус бүрээр Улаанбаатар хотын хүн амын дунд үүсэж буй уушгины хавдар, зүрхэнд цус хомсрох эмгэг, шигдээс, уушгины архаг бөглөрөлтөт өвчин, хүүхдийн (0-4 насны) амьсгалын доод замын цочмог халдвар зэрэг өвчлөлүүдийн эрсдэлийн хувийг тооцлоо. Дээрх таван төрлийн өвчлөлийн эрүүл мэндийн ачааллыг агаарын бохирдлоос үүдэлтэй цаг бус нас баралт (ЦБНБ) болон өвчлөлөөр алдсан амьдралын жилүүдээр (ӨААЖ) тооцсон ба энэ нь Эрүүл Мэндийн Хэмжилт, Үнэлгээний Хүрээлэнгийн 2010 онд гаргасан Дэлхийн Өвчлөлийн Ачааллыг Үнэлэх судалгааны улс орон, бүс нутаг, дэлхийн өвчлөлийн тооцоонд үндэслэн сонгосон (Муррай нар, 2012). Эдгээр нь өртөлтийн харьцангуй бодит хэмжээнд функцийн стандартад тохирч буй өвчлөлүүд боловч нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлттэй холбоотой уушгины сүрьеэ өвчнөөс шалтгаалсан нас баралтын эрсдэл нэмэгдэж буй талаар судлаачид тэмдэглэх болсон. Иймээс уушгины сүрьеэ өвчнийг агаарын бохирдлын эрүүл мэндийн нөлөөллийн хоёрдогч үр дагавар гэж авч үзсэн.²⁷

Цаг бус нас баралт ба Өвчлөлөөр алдсан амьдралын жилүүд

Нийслэлийн эрүүл мэндийн ачааллыг нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жилийн дундаж өртөлт 12 мкг/м³-ээс бага үед үүсэх өвчлөлтэй харьцуулах замаар тооцсон.²⁸ 2014-2024 оны хоорондох эрүүл мэндийн ачааллыг хувилбар тус бүрээр тооцов. Өртөлтийг дундаж хүн амын тархалтаар тооцсон. Суурь түвшин болон хувилбар тус бүрт 2024 оныг хүртэлх нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийн агууламжийг шугаман байдлаар илэрхийлсэн. Суурь түвшинд жилийн дундаж өртөлтийн түвшинг тооцож, түүнийг Төлөв 2013 болон туршилтын бусад нөхцлүүдийн хооронд адил гэж үзэн бусад хувилбаруудтай харьцуулсан. Бүх өртөлтийн шат дараалалтай тухайн оны эхний өдрийг жил бүрийн 1 дүгээр сарын 1-нээр буюу жишээлбэл 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс 2015 оны өртөлт эхэлнэ гэж тооцсон. Өртөлт арван жилийн турш өөрчлөгдөх ба хамгийн сүүлд 2024 оны 1 дүгээр сарын 1-нд байхаар тооцсон. Төлөв 2013 түвшин дэх эрүүл мэндийн ачааллыг ЦБНБ болон ӨААЖ-ээр 2014-2024 оны хооронд 11 жилээр жил тутамд тооцсон. Хавсралт Ж-ээс эрүүл мэндийн ачааллыг жил тутамд хувилбар тус бүрээр хэрхэн тооцсоныг харж болно. Өвчлөл нь уг загварт ӨААЖ-ээр тооцогдсон. ӨААЖ-ийг дэлхийн хэмжээнд гол төлөв цаг бус нас баралт болон амь насанд халтай бус өвчлөлийг тодорхойлоход ашигладаг. Мөн ӨААЖ-ийн тоо нь нэг америк доллар тутамд ногдож буй эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг үнэлэн эдийн засгийн тооцоог гаргах чухал үзүүлэлт болгон ажилдаг.

ӨААЖ-ийг тооцохдоо үндэсний хэмжээнд тодорхой-өвчлөлөөс шалтгаалсан нас баралтуудыг ашигладаг²⁹. ӨААЖ-ийн харьцааг Эрүүл Мэндийн Хэмжилт, Үнэлгээний Хүрээлэнгийн Дэлхийн Өвчлөлийн Ачааллын судалгаагаатай дүйцүүлэн тооцсон ба судалгааны хугацаанд тогтмол (өөрчлөлт байхгүй) байна гэж үзэв. Хувилбар тус бүрт нас баралт болон ӨААЖ-ийн бууралтыг тооцохдоо тухайн нөхцөл дэх нас баралт, ӨААЖ болон Төлөв 2013-ын тооны ялгаагаар тооцсон. 2024 оны хувьд үлдэж байгаа бусад эрүүл

²⁷ Энэ судалгааны нэг гол зорилт нь уушгины сүрьеэ, дутуу төрөлт, нүдний катаракт гэсэн 3 үндсэн агаарын бохирдлын хоёрдогч үр дагаврыг тооцох явдал байлаа. Гэвч, дутуу төрөлт, нүдний катаракт өвчинтэй холбоотой судалгаанд хамрагдах үеийн (2006-2012) суурь өвчлөлийн талаарх эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл нь хангалтгүй байсан тул бид эдгээр өвчнийг судалгаандаа хамруулсангүй.

²⁸ Энэ хэмжээ нь АНУ-ын Байгаль Хамгаалах Агентлагийн (EPA) нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) жилийн дундаж агаарын чанарын стандартыг төлөөлж буй бөгөөд энэ нь дэлхийн хэмжээнд одоогоор нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хамгийн хатуу тогтоосон стандарт юм.

²⁹ Жишээлбэл: агаарын бохирдлоос болоод өвчлөн цаашид нас барах гол шалтгаан нь болсон. Энэ нь тухайн хувь хүнээс хамаарахгүйгээр орчноосоо өвчлөлийн эх үүсвэрийг авсан буюу улсын хэмжээгээр өвчлөх юм.

мэндийн ачааллыг нас баралт болон ӨААЖ-ийн аль алинд нь тооцсон ба энэ нь 2024 онд хувилбар тус бүрийн хувьд Төлөв 2013-ын хүрээнд хүлээгдэж буй ачааллын эзлэх хувь юм. Дараах томъёог ашиглан тооцсон.

$$\text{2024 онд хүлээгдэж буй ачаалал} = \frac{\text{Тухайн хувилбарын 2024 онд хүлээгдэж буй ачаалал}}{\text{Төлөв 2013-ын 2024 онд хүлээгдэж буй ачаалал}} \times 100$$

Харьцангуй эрсдэл

Өвчлөл болон нас баралтыг тооцохдоо харьцангуй эрсдэлийн (ХЭ) функцийг ашигласан. Харьцангуй эрсдэлийг өвчлөл тус бүрийн хүн амд ногдох эрсдэлийн хэсгийг (ХАНХ) тооцоход ашигладаг. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) улмаас үүсэж буй үндсэн өвчлөлүүдийн харьцуулж болох эрсдэлийн хувийг дараах томъёогоор олно.

$$\text{ХАНХ} = \frac{(XЭ - 1)}{(XЭ - 1) + 1}$$

Харьцангуй эрсдэл нь өртөлтийн тодорхой түвшин дэх тухайн өвчлөлийн эрсдэл юм (Десай нар, 2004). Өвчлөл тус бүрт ХАНХ нь харилцан ялгаатай байдаг бөгөөд түүнийг тооцохдоо суурь түвшинг тухайн өртөлтийн хэмжээнээс хамаарч нэмэгдэж буй өвчлөлийн хувиар орлуулж тооцсон. Мөн ХАНХ-ийн дээд болон доод хязгаарын үзүүлэлтүүдийг тооцлоо.

Нас баралтын эрсдэлийн тун-хариу үйлдлийн муруйг 2010 оны Дэлхийн Өвчлөлийн Ачааллын судалгаанд ашигласан үзүүлэлтүүдээр тооцсон (Бурнетт нарын, 2014). Бүтцийн функциональ загвар нь энэ өгөгдөлд таарсан ба Eureka Formulize (Шмит нарын 2013)-ийн мэдээллийг ашигласан. Дээд болон доод тодорхойгүй хязгаар нь 95%-ийн итгэлцлийн хүрээнд багтаж тухайн өвчлөлийн эрсдэлийн нэгжийн утгыг тооцохдоо ашигласан. Харьцангуй эрсдэл 1-тэй тэнцүү үеийн нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт 7.3 мкг/м³ байж болох юм. Уг загварыг Хүснэгт Д1-т үзүүлэв.

Уушгины сүрьеэгийн тооцоо

Уушгины сүрьеэгийн харьцангуй эрсдэлийн томъёо шугаман аргаар OR-ээр (odds ratio) тодорхойлсон ба Хүснэгт Д2-т өртөлтийн түвшинг сүүлийн үеийн судалгаануудад тодорхойлсноор тусгасан. Нэгдүгээрт хамгийн их тохиолддог уушгины сүрьеэгийн OR, бусад судалгаанд тооцсонтой адилаар ашигласан. Хамгийн их хамааралтай эрсдэлийн мэдээллийг Непалын хийн түлш болон биомасс хэрэглэдэг эмэгтэйчүүдийн OR = 3.142-тэй (95%CI: 1.15, 8.56) харьцуулан тооцсон (Лакшми нар 2012). Энэхүү мэдээлэл нь сүүлийн үед хийгдсэн бусад судалгааны үр дүнгүүдтэй нийцэж байгаа юм (Смит нар, 2014). Учир нь нийт Непал дахь уушгины сүрьеэгийн эрсдэл 10% болон түүнээс бага байсан ба OR нь харьцангуй эрсдэлтэй тодорхойлогдсон байдаг (Какчапати нар, 2010). Тухайн хоёр бүлэгт нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт тодорхойлогдоогүйгээс хийн түлш хэрэглэгч эмэгтэйн нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт сүүлийн үед хэвлэгдсэн Энэтхэгт хийгдсэн судалгаагаар хийн түлш

хэрэглэдэг эмэгтэйчүүдийн өртөлт нь 70 мкг/м^3 , биомасс хэрэглэдэг эмэгтэйчүүдийн өртөлт 300 мкг/м^3 байна (Бурнетт нар, 2013). Иймд шугаман хамаарал нь 70 мкг/м^3 -д $OR = 1.0$, $1,300 \text{ мкг/м}^3$ -д $OR=3.14$ байна.


Тухайн OR-ийн хэвийн шугаман томъёоллыг өртөлтийн түвшин 1 байхаар тооцсон. Энэхүү томъёо нь сүрьеэгийн харьцангуй эрсдэлийн тэнцэтгэл болно. Бид цаг бус нас баралт болон ӨААЖ-ийн тодорхойгүй $\pm 50\%$ -ийг 50% -иар нэмж (дээшээ ихэссэн тохиолдолд), хасаж (доошоо буурсан тохиолдолд) тооцсон.

Хүснэгт Д2. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) харьцангуй эрсдэлийн томъёо

Зүрхэнд цус хомсрох эмгэг	$(IHD\ RR) = 0.9564 \cdot \log(\log(12.98 + PM))$
Доод тодорхойгүй хязгаар	$(Low\ IHD) = (41.12 + PM - 421.9 / (3.363 + PM))^{0.09225} - 0.2773$
Дээд тодорхойгүй хязгаар	$(Low\ IHD) = (2.281 + (-422.7 - 20.98 \cdot PM) / (435.4 + PM^2))$
Тархины шигдээс	$(Stroke\ RR) = 2.125 + (-172.9 - 19.42 \cdot PM) / (227.9 + PM^2)$
Доод тодорхойгүй хязгаар	$(Low\ Stroke) = (1.199 + 0.03729 \cdot PM)^{0.13}$
Дээд тодорхойгүй хязгаар	$(Stroke\ RR) = 2.075 + 5.204e-5 \cdot PM + (-710 - 8.422 \cdot PM) / (643.9 + PM^2 - PM)$
Уушгины архаг бөглөрөлтөд өвчин	$(COPD\ RR) = \sqrt{(1.398 + 0.00638 \cdot PM + -24.08 / (54.74 + PM))}$
Доод тодорхойгүй хязгаар	$(Low\ COPD) = 1.007 + 0.001675 \cdot PM + 2.848e-10 \cdot PM^3 - 7.654e-7 \cdot PM^2$
Дээд тодорхойгүй хязгаар	$(Up\ COPD) = \sqrt{(1.538 + 0.01125 \cdot PM + -17.93 / (27.84 + PM))}$
Уушгины хавдар	$(LC\ RR) = 1.015 + 0.00596 \cdot PM + 1.781e-8 \cdot PM^3 + 5.276e-15 \cdot PM^5 - 1.047e-5 \cdot PM^2 - 1.557e-11 \cdot PM^4$
Доод тодорхойгүй хязгаар	$(Low\ LC) = 0.9849 + 0.001803 \cdot PM - 2.049e-8 \cdot PM^2$
Дээд тодорхойгүй хязгаар	$(Up\ LC) = 1.032 + 0.01001 \cdot PM + 7.365e-8 \cdot PM^3 + 7.736e-14 \cdot PM^5 - 2.268e-17 \cdot PM^6 - 1.053e-10 \cdot PM^4 - 2.927e-5 \cdot PM^2$
Амьсгалын доод замын цочмог халдвар	$(ALRE\ RR) = (9304 + 27.36 \cdot PM + 3.328 \cdot PM^2) / (8704 + 38.75 \cdot PM + PM^2)$
Доод тодорхойгүй хязгаар	$(Lower\ CI) = \exp((23.51 \cdot PM + PM^2) / (6063 + 138 \cdot PM + PM^2))$
Дээд тодорхойгүй хязгаар	$(Upper\ CI) = (53.9 + 3.371 \cdot PM) / (65.26 + PM) - 0.02199 \cdot PM \cdot \exp(-0.01778 \cdot PM)$
Уушгины сүрьеэ	$(TB\ RR) = (0.0225 \cdot PM) + 0.8426$
Доод тодорхойгүй хязгаар	Тодорхойгүй
Дээд тодорхойгүй хязгаар	Тодорхойгүй

Шугаман бус өртөлтийн хариу үйлдэл

Тун-хариу үйлдлийн хамаарлын муруйг Бурнет нарын тодорхойлсноор ашигласан ба энэ нь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) агууламжийг бууруулж өртөлтийг маш бага түвшинд тооцох боломжийг олгосон юм (Бурнет нар, 2014). Зураг Д1-т харуулснаар нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлт болон шигдээс, зүрхэнд цус хомсрох эмгэг, амьсгалын доод замын цочмог халдвар зэрэг нь харьцангуй дээгүүр шулуун, харин уушгины хавдар, уушгины архаг бөглөрөлтөт өвчин зэрэг нь бараг шугаман байдлаар дүрслэгдсэн байна. Энэ нь эрүүл мэндийн эерэг үр дүн маш бага өртөлттэй үед гарахыг харуулж байна. Тиймээс эрүүл мэндийн бодит эерэг үр дүн өртөлтийн хэмжээг эрс бууруулсан үед гарч ирнэ (Смит нар, 2014).



Зураг Д1. Бурнет нарын *supra-linear* харьцангуй эрсдэлийн муруй (2014). Энэхүү судалгаанаас гарсан үндсэн 5 өвчлөлийн эрүүл мэндийн ачаалал болон тэдгээрийн харьцангуй эрсдэлийг харууллаа.

Эрүүл мэндийн хожуу үед илрэх нөлөөлөл

Эрүүл мэндийн ачаалал болон үр ашгийг 2014-2024 оны хооронд өртөлтийн зөрүүний улмаас цаг бус нас баралт болон ӨААЖ-ийн бууруулсан дүнгээр тооцсон. Хэдийгээр сүүлийн жилүүдэд нарийн ширхэглэгт тоосонцороос (PM2.5) хамааралтай маш олон өвчин хүн амд тархсан ба өртөлтийн үр дагавар нь урт хугацаанд үргэлжилж болзошгүй (өөрөөр хэлбэл, үр нөлөө нь өртөлтөөс хойш урт хугацааны дараа ч мэдрэгдэж байх) байгаа ч нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) өртөлтийн хэмжээг бууруулсны дараа холбогдох эрүүл мэндийн эрсдэл болон өртөлтийг бууруулснаар тухайн хугацааны эцэст тодорхой

тооны нас баралт, ӨААЖ-ээс сэргийлэх боломж бий болно (Долл нар, 2012).³⁰ ӨААЖ-ээс сэргийлэх талаар бидний таамаг нь эрүүл мэндийн эерэг үр дүн нэмэгдэх явдлыг эрчимжүүлэх ба тухайн хугацааны тооцоо ялимгүй өөрчлөгдсөн байна. Үүнийг харьцуулан бид шинжлэх ухааны зөвлөмж өгөх үүднээс АНУ-ын Байгаль, орчныг хамгаалах агентлагийн санал болгосны дагуу НАРІТ аргын тооцооны хуудаст ямарваа нэг зогсонги байдал үүсээгүй нөхцөлд болон 20 жилийн хугацаанд схемийн дагуу нас баралт, ӨААЖ, сэргийлж чадсан нас баралт, сэргийлж чадсан ӨААЖ-ийн үзүүлэлтийг харьцуулав (Камерон нар, 2004). Уг схемд өртөлтийг бууруулсан тухайн жилд нийт өвчлөлийн ачаалал 30%, 2-5 жилийн хугацаанд 50%-аар жигд тархацтайгаар 6-20 жил болоход 20%-аар жигд тархацтайгаар буурсан байна гэж дүрсэлсэн. Бодит үр дүнг харуулах үүднээс тооцоонд уушгины хатгалгааны хожуу үед илрэх нөлөөллийн хугацааг оруулаагүй болно.

Зардлын үр ашиг

Энэхүү үнэлгээнд зардлын үр ашгийн талаар тодорхой дүгнэлт өгөх боломжгүй юм. Гэсэн хэдий ч шинэчилсэн НАРІТ аргын тооцооны хуудсыг боловсруулснаар холбогдох байгууллагууд тухайн мэдээллийг ашиглан шаардлагатай дүнг гарах боломжтой юм. Энэхүү аргыг ашиглан зардлын үр ашигт байдлын дүн шинжилгээг хийхэд 1) эхлэлийн үеийн нийт зардал, 2) хөтөлбөр хэрэгжих хугацааны жилийн дундаж өртөг 3) хөтөлбөр хэрэгжих хугацааны нэг хүнд ногдох ДНБ гэсэн 3 нэмэлт мэдээлэл, тэдгээрийг нэг ижил тогтмол мөнгөн тэмдэгтийн ханшаар тооцно.³¹ Зардлын үр ашгийг олон улсын мөнгөн тэмдэгтээр ӨААЖ-ийн нэг хүнд ногдох ДНБ-д нөлөөлөх жил бүрийн зардалтай харьцуулан тодорхойлно. ДЭМБ-ийн баримталдаг хэмжээгээр зардлын үр ашиг нь интерванцын зардал нэг хүнд ногдох ДНБ-ээс бага байх нь хамгийн тохиромжтой бөгөөд ДНБ-тэй харьцуулахад 1-3 дахин их байвал үр ашигтай, харин 3 дахин илүү зардалтай бол ашиггүй гэж зөвлөсөн байдаг.

³⁰ Энэ дүрмээс ангид гол асуудал бол гол төлөв богино хугацаанд өртсөнөөс үүдэлтэй байдаг хүүхдийн амьсгалын замын архаг үрэвсэл юм.

³¹ Олон улсын тогтмол 2005 ам.долларыг зөвлөмж болгодог.

ХАВСРАЛТ Е.

АРГАЧЛАЛ БОЛОН ӨГӨГДЛИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЛУУД

Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ялгаралтын тооцоо

Улаанбаатар хотод хийгдсэн нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ялгаралтын хэмжилтүүд эрс тэс ялгаатай байдаг. Жишээлбэл 2010 онд хийсэн Гуттиканда нарын судлаачид (2013) болон ЖАЙКА байгууллагын судалгаанд ялгаралт нь эх үүсвэрээсээ шалтгаалан 10 болон түүнээс олон дахин ялгаатай байна. Халаалтын зуухны хувьд өөр хоорондоо харилцан адилгүй эх үүсвэрүүдтэй бол бусад тохиолдолд ялгаралтын эх үүсвэр нь төстэй боловч ялгаралтын тооцоо нэлээд ялгаатай байдаг. Ялгаралтын тооцоог илүү сайжруулах шаардлагатай бөгөөд нийцээгүй тохиолдолд аливаа загварын үр дүнг тодорхойлох боломжгүй юм. Тооцооны аргачлал нь ил тод бөгөөд хэрэглэгчид эдгээр аргачлалын давуу болон сул тал, юуг нь сайжруулах шаардлагатай талаар ойлгож мэдэх боломжтой байхаар хангалттай нарийн мэдээллийг агуулсан байх шаардлагатай. Ялгаралтын талаарх мэдээлэл нь нийслэлийн өвлийн онцгой хүнд нөхцлийг тусгасан байх ёстой. Тухайлбал, гадаад орчны нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ялгаралтыг тооцход зуухны яндангаас сорьц авах үед тухайн дотоод орчны температураас хамааран агаар холилдсонтой холбоотойгоор гадаад орчны бохирдлыг дутуу үнэлэх тал бий. Учир нь ялгаран гарсан хий дэх хагас дэгдэмхий элементүүд нь хүйтэн цагт гадаад орчны агаартай холилдон тоосонцор болдог. Энэхүү динамик үйл явц нь бүрэн шаталтын хэмжээ болон орчны нөхцлөөс шууд хамаарна.

Агаарын чанарын загварын сонголт

Гадаад орчны тоосонцорын хэмжээг тооцохдоо агаарын чанарын илүү боловсронгуй загвар шаардагдсан. Үүнд Гауссын ISCST-3 хэмээх урсгалын загварыг ашигласан. Гауссын урсгалын бүх загварууд нь тооцоолж буй хэмжээнд нөлөөлөх бодит үйл явцыг төдийлөн тооцож чаддаггүй. Улаанбаатар хотын нөхцөлд газрын хэвгий (уулын хөндий гэх мэт) зэрэг нь нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ялгаралтыг барьдаг бөгөөд дээрх загварыг ашиглан бохирдлын хэмжээг тооцход бодит байдлаас өндөр гарч болдог. Энэхүү загвар нь тухайн цагт ялгарсан нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) хэмжээнээс тухайн өгөгдсөн цагт бохирдлын хэмжээ ямар байхыг урьдчилан тооцдог. Энэ нь өмнөх цагт хэдий хэмжээний ялгаралтыг бүртгэсэн талаарх мэдээлэл байхгүй учраас нийслэлийн өвлийн улирлын бохирдуулагчийг тооцох боломжгүй юм. Уг загварт хотын хэмжээнд салхины чиглэл нэгэн жигд байдаг гэж үзсэн. Гэсэн хэдий ч газрын хэвгий бүр агаарын урсгалыг өөрчлөх ба хотын хэмжээнд агаарын нөхцөл байдал ихээхэн ялгаатай байх магадлалтай. Иймд заримдаа агаарын урсгалын хэлбэрүүд хязгаарлагдмал байдлыг үүсгэж болох ба химийн бодисын тээвэрлэлтийн загварыг ашиглахыг зөвлөдөг. Гэвч өгөгдөлийн параметрийг боловсруулахад болон нийслэлийн нөхцөл байдалд нийцсэн загвар гаргахад ихээхэн хөрөнгө шаардлагатай юм.

Гадаад орчны агаарын чанарын өгөгдөл

Гадаад орчны тоосонцорын мэдээллийг тухайн хяналтын цэгтэй хамгийн ойр орших эх үүсвэрт хүчтэй шууд нөлөөлөхгүй байх цэгээс нь цуглуулсан. Тухайн сүлжээг хэмжилт хийхэд чиглэж маш анхааралтай загварчилсан байх ёстой байдаг. Жишээлбэл зам

талбайн хяналт нь замын эргэн, тойрон хүрээлэн буй орчны бохирдолтын түвшний мэдээллийг хангадаг ч хөдөө орон нутаг болон томоохон талбайг хамарсан агаарын чанарыг хянахад төдийлөн тохиромжтой бус юм. Мөн хэмжилтийн алдааг хамгийн бага байлгахын тулд Улаанбаатар хотын өвлийн нөхцөлд тусгайлан зориулсан хэмжилтийн арга хэрэгтэй. Тухайлбал, гадаад орчны агаар дахь тоосонцорын хагас хувирамтгай нэгдлүүд салах хэмжээ нь дулаан нөхцөлд гэрийн автомат хэрэгслүүдэд ашигласан болон шүүлтүүрт цуглуулсаны дараа лабораторид авчрах үеийнхтэй харилцан адилгүй байна. Өгөгдлийг зөв тайлбарлах болон хэрэглэхэд энэхүү динамик үйл явцыг тооцох шаардлагатай.

Эрүүл мэндийн нөлөөлөл

Энэхүү судалгаанд эрүүл мэндийн ачааллыг суурь өвчлөлийн төлөв дэх ирээдүйн өвчлөлийн хандлагаар тооцсон тул ирээдүйд төлөвлөж байснаасаа өөрчлөгдөх боломжтой. Иймд бид өөрсдийн судалгааны хамрах хүрээг 10 жилээр авч үзсэн юм. Мөн түүнчлэн

- Энэхүү судалгаанд ашигласан загварууд нь суурь түвшний эрүүл мэндийн ачааллын хамаарлыг тооцох харьцангуй энгийн арга бөгөөд ирээдүйн нөхцлийг тооцох боловсронгуй аргыг ашиглах нь илүү үр дүнтэй байж болно.
- Эрүүл мэндийн хожуу үед илрэх нөлөөллөөс шалтгаалан, 2006-2012 оны нас баралтын бүртгэл нь агаарын бохирдлын сүүлийн үеийн чиг хандлагыг тодорхойлоход хангалтгүй үзүүлэлт юм.
- Тиймээс 2006-2012 оны эрүүл мэндийн статистик мэдээлэлд үндэслэн боловсруулсан бидний үнэлгээ нь эрүүл мэндийн суурь түвшний үеийн үзүүлэлтийг (нас баралт) ашигласан нь бодит байдлын хамгийн бага хувь юм.

Хувилбар тус бүрийн хувьд нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) ертөлтийн жилийн суурь түвшин болгон авсан 2014 оноос, туршилтын сүүлийн жил болох 2024 оны хооронд жил бүрийн шугаман прогрессоор авч үзсэн. Энэ нь гадаад орчны загварчлалд интервенцүүдийн эрчимтэй нэмэгдэл, хүн амын огцом өөрчлөлт, хүн амын нягтаршлын хэвшмэл бус өөрчлөлт зэргийг зөвхөн тойм байдлаар илтгэх юм. Уг судалгаанд гүдгэр функц болгон ашигласан хэд хэдэн IER муруйгаар тухайн орон нутагт оршин сууж буй иргэдийн эрүүл мэндийн үзүүлэлтийг жил жилээр ертөлтийн өсөлт, бууралтаар дүрсэлсэн.

ӨААЖ-ийг тооцохдоо улсын хэмжээнд тодорхой өвчнөөс шалтгаалсан нас баралтын хэмжээг ашигласан. Энэхүү хэмжээг тооцохдоо Эрүүл Мэндийн Хэмжилт, Үнэлгээний Хүрээлэнгээс гаргасан Дэлхийн Өвчлөлийн Ачаалалд тооцсонтой адил хувийг ашиглалаа. Тооцоолсон хэмжээ нь насны бүтэц өөрчлөгдөхтэй холбоотойгоор хувьсах хандлагатай ч ямар чиглэлд өөрчлөгдөхийг урьдчилан тооцох боломжгүй юм.

Хотын өсөлтийн хувилбар

Орон сууцны барилга хэрхэн нэмэгдэх зэрэг нийслэл хотын хотжилтын хөгжлийн цаашдын төлвийг Хотын Ерөнхий Төлөвлөгөөнөөс авсан. Өртөлт болон эрүүл мэндийн тооцоо нь ерөнхий төлөвлөгөөний биелэлтээс шалтгаалан тодорхой хувиар өөрчлөгдөх магадлалтай. Үүний нэгэн адил нийслэл хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний хэмжээг өмнөх жилүүдийн өсөлтийн хурдтай адил байхаар таамаглан тооцсон боловч

дараагийн 10 жилд энэ хурд өөрчлөгдөх магадлалтай. Тухайн өөрчлөлтийг урьдчилан таамаглахад хүндрэлтэй юм.

Тамхидалт

Хэдийгээр өвчлөлийн хэмжээг тооцохдоо идэвхтэй тамхидалтаас үүсэх эрүүл мэндийн нөлөөг тооцдоггүй боловч энэ нь өнөөгийн суурь өвчлөлийн тархалтын түвшинд нөлөөлж байна. Тамхидалтын түвшин ихээхэн нэмэгдэж буй нь бусад эх үүсвэрийн ялгаралтыг бууруулсанаар гарах үр дүнгээс давах магадлалтай тул эрүүл мэндэд үзүүлэх нөлөө эрс ихсэх болзошгүй. Түүнээс гадна мэргэжлээс шалтгаалсан ажлын байран дахь тамхидалт нь өртөлтийг улам бүр нэмэгдүүлж байгаа боловч үүнийг бид загвартаа тусгаагүй болно.

Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээ

Дотоод орчны агаарын бохирдлын хэмжээг зуухны ялгаралт болон тамхидалтаар голчлон тооцсон. Хэдийгээр дээрх бохирдуулагч эх үүсвэрийн ялгаралт буурсны хирээр замын хөдөлгөөн болон гадаад орчны бусад эх үүсвэрүүд, хоол хийх, зул барих, цэвэрлэгээ хийх зэрэг гэрийн нөхцөл дэх бусад эх үүсвэрүүдээс ялгарах бохирдлын эзлэх хувь ихэснэ. Энэхүү судалгаанд бид зуухны ялгаралт болон тамхидалтыг голчлон анхаарч үзсэн боловч төвийн халаалттай айлуудын дотоод орчны бохирдлын хэмжээ төдийлөн буурахгүй байх магадлалтай юм.

Аж үйлдвэрийн ялгаралт

Нийслэл дэх гадаад орчинд үйлдвэрийн эх үүсвэрээс ялгарч буй бохирдуулагчийн тоо болон тэдгээрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг байна. Эдгээр хүчин зүйлс нь нийслэлийн агаарын чанарт ихээхэн нөлөөлж байгаа хэдий ч одоогоор эдгээр ялгаралтын эх үүсвэрийг тооцоолоогүй болно.

Нүүрсний төрөл

Нийслэлд олон төрлийн нүүрсийг хэрэглэж байгаагаас ихэнх айл өрхүүд Налайх, Багануур болон Алагтолгойн нүүрсийг хэрэглэж байна. Тэдгээрийн харьцаа болон өрхийн зуухны төрлөөс хамааран ялгарч буй бохирдлын хэмжээ харилцан ялгаатай байна. Зууханд хэрэглэж буй түлшний шаталтыг сайжруулахад нийслэлийн түлшний талаар баримтлах бодлого ихээхэн анхаарч ажилласан. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бусад арга хэмжээнд сөргөөр нөлөөлөх зуухны утааны ялгаралтыг нэмэгдүүлэх нүүрсний төрлийг дэмжихгүй байх бодлогод хэрэгжүүлэхийг бид зөвлөж байна. Үүнтэй нэгэн адил өрхийн ашиглаж буй зуухны утааны ялгаралтыг нэмэгдүүлэхгүй байх үүднээс бүрэн шаталттай нүүрсийг шалгах туршилтыг тухайн түлшийг хэрэглэж эхлэхээс өмнө хийх шаардлагатай. Хувилбар 1-т бид “Ирээдүйн технологийн зуух” гэсэн төрлийг шинээр оруулсан ба энэ нь МСС-ийн хөтөлбөрийн дүнд нэвтрүүлсэн ялгаралтыг бууруулах хэмжээтэй ижил хэмжээнд бууруулах шинэ төрлийн зуух байхаар тооцсон. Дээр дурьдсанчлан, дотоод орчны агаарын бохирдлыг бууруулдаг зуух ашиглахад анхаарах замаар эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм. Гэхдээ түлшний талаарх бодлогууд нь чанар муутай түлшийг дэмжвэл ялгаралт нь нэмэгдэж болзошгүй.

ХАВСРАЛТ Ё.

ХҮН АМ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хүн амын мэдээлэл

Бид 2006-2012 оны хоорондох нийслэлийн нийт хүн амын тоог албан ёсны бүртгэл болон хэвлэгдсэн материалаас авч судалгаандаа ашигласан (Мэндсайхан нар, 2011; Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо (ҮСХ), 2007; Нийслэлийн Статистикийн алба 2013).

2006, 2007, 2011, 2012 оны байдлаар таваас доош насны хүн амын мэдээллийг цуглуулсан ба 2008-2010 оны дүнг 2007 болон 2011 оны хооронд шугаман хамааралтай шулуун татан тооцсон.

2010, 2015, 2020, 2025, 2030 онуудын нийслэлийн хүн амын төлөв байдлын (нийт хүн ам ба таваас доош насны хүн амын) мэдээллийг ҮСХ-оос авсан. 2014-2030 оны хоорондох төлөвлөлтийг 2010 онд хийгдсэн хүн амын тооллогын нэгдсэн дүнг ашигласан ба (Зураг Ё1) хүн амын 5 жилийн дундаж өсөлттэй төлөвлөгөөг шугаман хамаарлаар харуулсан. 2012 оны дүүргүүдийн хүн амын тоон мэдээллийг нийслэлийн хүн амын тооллогын мэдээнээс авсан. Хүн амын өсөлтийн төлөв болон тооцоог Хүснэгт Ж1-д үзүүлэв. Дүүрэг тус бүрийн хүн амын хотын нийт хүн амд эзлэх хувь нь судалгааны хугацаанд тогтмол байна гэж үзлээ.


Өрхийн хэлбэрүүд

Жил бүрийн нийт айл өрхийн тооллогын дэлгэрэнгүй мэдээлэл байгаагүй болно. Иймээс бид хүн амын нэгдсэн тооллогод тодорхойлсон хүн ам ба ам бүлийн талаарх мэдээллийг ашигласан. Өмнө дурьдсанчлан хүн амын тоон мэдээлэл нь ҮСХ-ны тооцоо, хэтийн төлөвтэй харилцан хамааралтай байна. Ам бүлийн тоо нь Монгол Улсын жилийн статистикийн эмхэтгэлд дурдсан өмнөх жилүүдийн тоон үзүүлэлтийн (2000-2010) муруйгаар илэрхийлэгдсэн. Шугаман хамаарал нь цөөн ам бүлтэй өрхийн тоог нэмэгдүүлж байсан тул бид илүү бодитой тооцоо гаргах зорилгоор нийт төрөлтийн хэмжээний хандлагыг ашигласан. Нийт төрөлтийн хэмжээг НҮБ-ын тодорхойлсоноор эмэгтэйчүүд нөхөн үржихүйн насандаа төрөх магадлалтай хүүхдийн дундаж тоог төрөлтийн түвшин болон эндэгдлийн хэмжээнд харьцуулсан байдлаар хүн амын өсөлтөөр тооцсон. НҮБ-ын 5 жилийн нийт төрөлтийн хэмжээний тооцоог өгөгдөл авч болох 10 жилийн хугацаан дахь өрхийн хэмжээний талаарх тоо мэдээлэлтэй харьцуулан загварчлах нь энэхүү хоёр үзүүлэлтийн хоорондын хамаарлыг тогтооход нэмэр болохгүй учир бид гэр бүлийн хэмжээ нь үндэсний нийт төрөлтийн хэмжээний хандлагыг дагана гэж үзсэн. Монгол Улсын нийт төрөлтийн хэмжээ нь сүүлийн 10 жилүүдэд ихээхэн буурсан боловч цаашид нэмэгдэнэ гэж үзэж байна. НҮБ-аас Монгол Улсын эмэгтэйчүүдийн төрөлтийн тоо 2030 он гэхэд Барууны түвшинд ойртож тогтворжино гэж үзсэн (НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн алба (UN DESA): Хүн амын хэлтэс, 2013). 2000-2010 онуудад ажиглагдсан ам бүлийн тооны бууралт нь огцом, шугаман бууралт байсан боловч ойрын ирээдүйд энэ үзүүлэлт тогтворжих төлөвтэй байна. Иймээс бид 2010 оны байдлаар нэг өрх 2,6 ам бүлтэй байсан АНУ-ын ам бүлийн дундаж хэмжээтэй ойролцоо муруйг гаргах үүднээс Eureka томъёог ашигласан (Шмит нар 2009, Бюреау 2012).³¹ 2010-2030 оны жил бүрийн өрхийн хэмжээг энэхүү муруйгаас авсан (Зураг Ё2). Ам бүлийн өрхийн тоог жил тутмын нийслэлийн хүн амын тоог ам бүлийн дундаж хэмжээнд хувааж тооцов.


Нийслэлийн хувьд өрхийн оршин сууж буй гол хэлбэр нь гэр, байшин болон орон сууц гэж тооцов. Гэр нь гол төлөв мод, эсгийгээр хийсэн монголын уламжлалт сууц, байшин нь гэр биш, гол төлөв мод, цемент, тоосгоор барууны уламжлалт хэв маягаар барьдаг нэг гэр бүл амьдрах сууц, харин орон сууц нь хоёр ба түүнээс олон ихэвчлэн хэдэн арван айл амьдардаг том байшин сууцыг хэлнэ.

Гэр болон байшин нь нийслэлийн Статистикийн албанаас “гэр суурьшил” гэж тодорхойлсон бүсэд нийтлэг байдаг бол орон сууцанд амьдардаг өрхүүд нь “орон сууцны хороолол” гэгдэх газруудад хамгийн нийтлэг, олноороо байна. Нийслэлийн оршин суугчдад “гэр суурьшил”-д оршин суугчдын эзлэх хувийн (%-гэр) тоо мэдээллийг нийслэлийн 2010, 2020, 2030 онуудын хот төлөвлөлтөөс авсан. Жил бүрийн хандлага нь шугаман хамааралтай байна (Зураг Ё1). Гэр суурьшилд оршин суух өрхийн эзлэх хувийг гэр хороололд амьдарч буй оршин суугчдын эзлэх хувиас гаргав (%-гэр). Нийслэлийн “орон сууцны хороолол”-д амьдарч буй өрхийн эзлэх хувь (%-apartment)-ийг жил тутмын хувьд 1-%гэр гэж тооцоолов. Нийслэлийн Статистикийн албанаас орон сууцны суурьшлын өрхийн 99 орчим хувийг “орон сууц”-нд оршин суугч өрх гэж тодорхойлсон бөгөөд бусад хэлбэрийн сууцанд оршин суугчдыг бидний орон сууцны суурьшлын хувьд хийсэн тооцоонд төдийлөн ач холбогдолгүй гэж үзсэн.³²Гэвч Статистикийн албанаас гаргасан тоон мэдээллээс харахад гэр суурьшил дахь “гэр” болон “байшин”-д амьдарч буй өрхүүд харьцангуй жигд тархсан байна. 2012 оны байдлаар, гэр суурьшлын 44.2% (%-гэр_{гэр}) нь гэрт оршин сууж буй бол байшинд амьдарч буй өрх гэр суурьшлын нийт өрхийн 54.5%-ийг (%-гэр_{байшин}) эзэлж байна. Үлдэж буй хэсэг нь гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь нь тодорхой хязгаарын дотор багтаж байгаа тул бид энэ үзүүлэлтийг судалгаандаа оруулаагүй бөгөөд гэр хороололд “байшин”-нд амьдардаг өрхийн (%-гэр_{байшин}) хувийг тооцохдоо 1-%-гэр_{гэр} гэж тооцоолсон. %-гэр_{гэр} болон %-гэр_{байшин} үзүүлэлтийн хандлага төлвийн талаарх найдвартай мэдээлэл байхгүй байсан тул 2013-2030 оны хооронд тогтмол байна гэж үзэв. Хороолол, оршин сууж буй сууцны төрлөөр нийт өрхийн тоог Зураг Ё3-д харуулав.


³² Өрхийн халаалтаас ялгаруулж буй ялгаруулалтыг хотын Статистикийн албанаас тодорхойлсон “тансаг байшин” болон “орон гэргүй” өрхүүдийн хувьд тооцож гаргаагүй. Учир нь эдгээр нь нийт орон сууцны сууришлын ердөө 0.9% ба 0.01% харин нийт гэр сууришлын 1% ба 0.2 % хувийг тус тус эзэлж байна.



Зураг Ё1. 2013-2030 оны хүн амын тооны хандлага, орон сууцны болон гэр суурьшлын хүн амын тархалтаар. Нийт хүн ам тогтвортой өсөх бөгөөд гэр суурьшлын хүн амын тоо буурна гэж тооцож байна.



Зураг Ё2. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан болон 2011-2030 оны нийт төрөлтийн хэмжээний шугаман хамаарал, дээрх төлвийг ашиглан тооцсон 2000-2010 оны нэг өрхийн ам бүлийн тооны цаашдын төлөв.



Зураг Ё3. 2010-2030 оны байршил болон өрхийн оршин суугаа хэлбэрээр өрхийн тооны хэтийн төлөв, хандлага. Орон сууцны хороолол дахь өрхийн тоо нэлээд хэмжээгээр нэмэгдэнэ.

Өвчлөлийн суурь үзүүлэлт

Хувилбар тус бүрээр нас баралтыг тооцлоо. Судалгаанаас өмнөх жилүүдийн нас баралтын мэдээлэл, түвшинг тогтоосон нь 2014-2024 оны хоорондох нас баралтын түвшинг тооцоход чухал тоон үзүүлэлт болсон. 2006-2012 оны хоорондох нас баралтын өгөгдлийг Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо болон Эрүүл Мэндийн Яамны харьяа Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн мэдээллээс авлаа. 2010 онд хийгдсэн Дэлхийн Өвчлөлийн Ачааллын судалгаанд ашигласан нас баралтын дүн мэдээлэлтэй дүйцүүлэх зорилгоор Өвчний Олон Улсын X ангилалыг (ICD-10) ашигласан (Хүснэгт Ё1). Дурьдсан хугацаан дахь тодорхой өвчнөөс шалтгаалсан нас баралтын цаашдын хандлагыг хугацаа (жил) болон хүн амзүйн үзүүлэлтийн шугаман функцээр загварчлав (Хүснэгт E-2). Томъёо тус бүр дараах байдлаар бичигдсэн.

$$\text{Тухайн } X \text{ жилийн нас баралтын тоо} = \beta_0 + \beta_1 \times \text{Жил} + \beta_2 \times \text{Нийт хүн ам}$$

“Нийт хүн ам” гэдэг нь тухайн X он дахь хүн амын тоо, “Жил” гэж X оныг төлөөлөх ба энэ нь 4 оронтой тоо (жишээлбэл 2009) байна. Тухайн өвчлөлийн загвар нь 2014-2024 онуудад гарсан нас баралтын түвшинг үзүүлсэн. 2006-2012 оны хүн амын тоон өгөгдлийг (нийт хүн ам ба хүүхэд) жил бүрийн үндэсний статистикийн эмхэтгэл тайланг ашигласан (Мэндсайхан нар, 2011; Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, 2007). Нийт хамрагдсан өвчлөлүүдийн нас баралтын тооцоог Хүснэгт Ж1-д дэлгэрэнгүй үзүүлэв. 2024 он хүртэлх хүн амзүйн төлөвлөлтийг энэхүү хавсралтад өмнө нь дурдсан хүн амзүйн судалгааны аргуудыг ашиглан таамаглан гаргав.

Хүснэгт Ё1. Эрүүл мэндийн нөлөөллийн хэмжигдэхүүний ICD10 and ICD9 кодын нэрс болон өвчлөлүүдийн төрөл (ICD кодыг 2010 оны Дэлхийн Өвчлөлийн Ачааллын судалгаатай дүйцүүлэн сонгосон).

Өвчний нэр	ICD10 дугаарбүлэг	ICD9 дүгээрбүлэг
<i>Зүрх судасны өвчлөлүүд</i>		
Зүрхэнд цус хомсрох эмгэг	I20-I25	410-414
Шигдээс	I63, I65-I67 (I67.4-с бусад), I69.3	433-434, 437.0-437.2, 437.5-437.8
Цус алдалтын болон тархины гэмтлийн бус гаралтай бусад цус харвалт	I60-I62, I69.0-I69.2, I67.4	430-432, 437.2
Уушгины хавдар (мөгөөрсөн хоолойн, бронхи, уушгины хавдар)	C33-C34, D02.1-D02.2, D38.1	162-162.9, 231.1, 231.2, 231.8, 235.7
<i>Бүх төрлийн амьсгалын замын архаг үрэвслүүд</i>		
Уушгины архаг бөглөрөлтөд өвчин	J40-J44, J47	490-492.8, 494, 496
<i>Бүх амьсгалын доод замын архаг халдварууд, < 5 нас</i>		
Томуу	J09-J11	487
Str.pneumonia-аар сэдээгдсэн уушгины хатгалгаа	J13	481
Neatophylus influenza-аар сэдээгдсэн уушгины хатгалгаа (В хэв шинж)	J14	482.2
Амьсгалын синзитиал вируст уушгины хатгалгаа	J12.1	480.1
Бусад амьсгалын доод замын халдварууд	J12 (J12.1-с бусад), J15-J22, J85, P23	466, 480.0-480.9 (480.1-с бусад), 482.0-482.9 (482.2-с бусад), 483-486, 513, 770.0
<i>Хоёрдогч өвчлөлүүд</i>		
Сүрьеэ	A15-A19, B90, P37.0	010-018, 137.0-137.4, 320.4, 730.4-730.6

ХАВСРАЛТ Ж.

Эрүүл мэндийн ачааллын нэмэлт хүснэгт

Хүснэгт Ж1А. Хувилбар тус бүр дэх өвчлөлийн суурь үзүүлэлтүүд

Он	Хүн ам	Хүн ам (0-4 нас)	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдраас шалтгаалсан нас баралт	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдрын ӨААЖ	Амьсгалын доод замын халдвараас шалтгаалсан нас баралт (0-4 нас)	Амьсгалын доод замын халдварын ӨААЖ (0-4 нас)	УАБӨ-өөс (Уушгины архаг бөглөрөлтөт өвчин) шалтгаалсан нас баралт	УАБӨ-ний ӨААЖ
2014	1,355,176	148,219	227	5,678	416	35,640	425	16,621
2015	1,407,196	155,551	233	5,826	435	37,290	453	17,739
2016	1,459,516	158,438	239	5,974	454	38,927	482	18,845
2017	1,511,836	161,325	245	6,122	473	40,565	510	19,952
2018	1,564,157	164,212	251	6,270	493	42,203	538	21,059
2019	1,616,477	167,099	257	6,418	512	43,841	566	22,165
2020	1,668,797	169,986	263	6,566	531	45,478	595	23,272
2021	1,715,748	168,427	269	6,723	552	47,325	628	24,583
2022	1,762,700	166,869	275	6,881	574	49,173	662	25,895
2023	1,809,651	165,310	281	7,039	595	51,020	695	27,206
2024	1,856,603	163,752	288	7,196	617	52,867	729	28,517

Хүснэгт Ж1Б. Хувилбар тус бүр дэх өвчлөлийн суурь үзүүлэлтүүд

Он	Хүн ам	Хүн ам (0-4 нас)	ЗЦХЭ (Зүрхэнд цус хомсрох эмгэг) нас баралтаар	ЗЦХЭ-ийн ӨААЖ	Шигдээс, цус алдатын болон цус хомсролын бус бусад цус харвалтаас шалтгаалсан нас баралт	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтын ӨААЖ	Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт	Сүрьеэгийн ӨААЖ
2014	1,355,176	148,219	2,064	45,975	1,471	33,808	155	8,963
2015	1,407,196	155,551	2,151	47,903	1,493	34,321	156	8,973
2016	1,459,516	158,438	2,237	49,823	1,516	34,832	156	8,989
2017	1,511,836	161,325	2,323	51,744	1,538	35,343	156	9,005
2018	1,564,157	164,212	2,409	53,665	1,560	35,855	156	9,021
2019	1,616,477	167,099	2,495	55,585	1,582	36,366	157	9,037
2020	1,668,797	169,986	2,582	57,506	1,605	36,877	157	9,053
2021	1,715,748	168,427	2,674	59,556	1,628	37,410	155	8,963
2022	1,762,700	166,869	2,766	61,606	1,651	37,942	154	8,873
2023	1,809,651	165,310	2,858	63,656	1,674	38,474	152	8,783
2024	1,856,603	163,752	2,950	65,706	1,697	39,006	151	8,693

Хүснэгт Ж2А. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) суурь өртөлтийн үеийн (12 мкг/м³) өвчлөлийн ачаалал

Он	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдраас шалтгаалсан нас баралт PM2.5-аас хамааралтай	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдраас шалтгаалсан нас баралт PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдрын ӨААЖ PM2.5 -аас хамааралтай	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдрын ӨААЖ PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Амьсгалын доод замын халдвараас шалтгаалсан нас баралт (0-4 нас) PM2.5 -аас хамааралтай	Амьсгалын доод замын халдвараас шалтгаалсан нас баралт (0-4 нас) PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Амьсгалын доод замын халдвараас шалтгаалсан нас баралт (0-4 нас) PM2.5-аас хамааралтай (1000 хүүхдэд)	Амьсгалын доод замын халдварын ӨААЖ (0-4 нас) PM2.5-аас хамааралтай	Амьсгалын доод замын халдварын ӨААЖ (0-4 нас) PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Амьсгалын доод замын халдварын ӨААЖ (0-4 нас) PM2.5-аас хамааралтай (1000 хүүхдэд)	УАБӨ-өөс шалтгаалсан нас баралт PM2.5-аас хамааралтай	УАБӨ-өөс шалтгаалсан нас баралт PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	УАБӨ-ний ӨААЖ PM2.5-аас хамааралтай	УАБӨ-ний ӨААЖ PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)
2014	18	0.013	445	0.328	33	0.024	0.222	2815	2.077	18.990	22	0.016	872	0.643
2015	18	0.013	457	0.324	34	0.024	0.221	2945	2.093	18.932	24	0.017	930	0.661
2016	19	0.013	468	0.321	36	0.025	0.226	3074	2.106	19.404	25	0.017	988	0.677
2017	19	0.013	480	0.317	37	0.025	0.232	3204	2.119	19.858	27	0.018	1046	0.692
2018	20	0.013	491	0.314	39	0.025	0.237	3333	2.131	20.297	28	0.018	1104	0.706
2019	20	0.012	503	0.311	40	0.025	0.242	3462	2.142	20.720	30	0.018	1162	0.719
2020	21	0.012	515	0.308	42	0.025	0.247	3592	2.152	21.129	31	0.019	1220	0.731
2021	21	0.012	527	0.307	44	0.025	0.259	3737	2.178	22.190	33	0.019	1289	0.751
2022	22	0.012	539	0.306	45	0.026	0.272	3883	2.203	23.272	35	0.020	1358	0.770
2023	22	0.012	552	0.305	47	0.026	0.284	4029	2.227	24.374	36	0.020	1427	0.788
2024	23	0.012	564	0.304	49	0.026	0.298	4175	2.249	25.497	38	0.021	1496	0.806

Хүснэгт Ж2Б. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) суурь өртөлтийн үеийн (12 мкг/м³) өвчлөлийн ачаалал

Он	3ЦХЭ-ээс (Зүрхэнд цус хомсрох эмгэг) шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	3ЦХЭ-ээс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	3ЦХЭ-ийн ӨААЖ PM2.5-аас хамааралтай	3ЦХЭ-ийн ӨААЖР M2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтаас шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтаас шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтын ӨААЖ, PM2.5-аас хамааралтай	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтын ӨААЖ, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Сүрьеэгийн ӨААЖ, PM2.5-аас хамааралтай	Сүрьеэгийн ӨААЖ, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)
2014	218	0.161	4846	3.576	48	0.035	1095	0.808	16	0.012	907	0.669
2015	227	0.161	5049	3.588	48	0.034	1112	0.790	16	0.011	908	0.645
2016	236	0.162	5252	3.598	49	0.034	1128	0.773	16	0.011	910	0.623
2017	245	0.162	5454	3.608	50	0.033	1145	0.757	16	0.010	911	0.603
2018	254	0.162	5657	3.616	51	0.032	1161	0.742	16	0.010	913	0.584
2019	263	0.163	5859	3.625	51	0.032	1178	0.729	16	0.010	915	0.566
2020	272	0.163	6061	3.632	52	0.031	1194	0.716	16	0.010	916	0.549
2021	282	0.164	6277	3.659	53	0.031	1212	0.706	16	0.009	907	0.529
2022	292	0.165	6494	3.684	53	0.030	1229	0.697	16	0.009	898	0.509
2023	301	0.166	6710	3.708	54	0.030	1246	0.689	15	0.009	889	0.491
2024	311	0.167	6926	3.730	55	0.030	1263	0.680	15	0.008	880	0.474

Хүснэгт Ж3А. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) Төлөв 2013-ын үеийн өвчлөлийн ачаалал

Он	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдраас шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдраас шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдрын ӨААЖ, PM2.5-аас хамааралтай	Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушгины хавдрын ӨААЖ, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Амьсгалын доод замын халдвараас шалтгаалсан нас баралт (0-4 нас), PM2.5-аас хамааралтай	Амьсгалын доод замын халдвараас шалтгаалсан нас баралт (0-4 нас), PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Амьсгалын доод замын халдвараас шалтгаалсан нас баралт (0-4 нас), PM2.5-аас хамааралтай (1000 хүүхдэд)	Амьсгалын доод замын халдварын ӨААЖ, (0-4 нас) PM2.5-аас хамааралтай	Амьсгалын доод замын халдварын ӨААЖ, (0-4 нас) PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Амьсгалын доод замын халдварын ӨААЖ, (0-4 нас) PM2.5-аас хамааралтай (1000 хүүхдэд)	УАБӨ-өөс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	УАБӨ-өөс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	УАБӨ-ний ӨААЖ, PM2.5-аас хамааралтай	УАБӨ-ний ӨААЖ, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)
2014	62	0.046	1555	1.147	166	0.122	1.119	14214	10.489	95.901	93	0.068	3625	2.675
2015	64	0.046	1605	1.141	175	0.124	1.124	14979	10.644	96.294	99	0.071	3891	2.765
2016	66	0.045	1656	1.135	184	0.126	1.160	15746	10.789	99.384	106	0.073	4158	2.849
2017	68	0.045	1707	1.129	193	0.128	1.195	16521	10.928	102.411	113	0.075	4427	2.928
2018	70	0.045	1759	1.124	202	0.129	1.230	17304	11.063	105.379	120	0.077	4699	3.004
2019	72	0.045	1811	1.120	211	0.131	1.264	18095	11.194	108.289	127	0.079	4973	3.077
2020	75	0.045	1863	1.116	221	0.132	1.297	18893	11.321	111.143	134	0.080	5250	3.146
2021	77	0.045	1919	1.118	231	0.135	1.371	19785	11.532	117.471	142	0.083	5576	3.250
2022	79	0.045	1975	1.120	241	0.137	1.447	20686	11.735	123.966	151	0.086	5905	3.350
2023	81	0.045	2031	1.122	252	0.139	1.525	21595	11.933	130.632	159	0.088	6237	3.446
2024	83	0.045	2088	1.125	263	0.142	1.605	22511	12.125	137.473	168	0.090	6572	3.540

Хүснэгт ЖЗБ. Нарийн ширхэглэгт тоосонцорын (PM2.5) Төлөв 2013-ын үеийн өвчлөлийн ачаалал

Он	3ЦХЭ-ээс (Зүрхэнд цус хомсрох эмгэг) шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	3ЦХЭ-ээс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	3ЦХЭ-ийн ӨААЖ, PM2.5-аас хамааралтай	3ЦХЭ-ийн ӨААЖ, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтаас шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтаас шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтын ӨААЖ, PM2.5-аас хамааралтай	Шигдээс, цус алдалтын болон цус хомсролын бус бусад цус харвалтын ӨААЖ, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай	Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)	Сүрьеэгийн ӨААЖ, PM2.5-аас хамааралтай	Сүрьеэгийн ӨААЖ, PM2.5-аас хамааралтай (1000 хүн амд)
